$$\Psi_i(\vec{p}) = \frac{1}{(2\pi)^3} \int d\vec{r} \Psi_i(r) e^{i\vec{p}\vec{r}} = \frac{2\sqrt{2}}{\pi(p^2 + 1)^2}. \quad (15)$$

Матрицын элементийг энэхүү Фурье дүрийн уламжлалаар илэрхийлж болно.

$$(2\pi)^3 \frac{d}{d\vec{p}} \Psi_i(\vec{p}) = i \int e^{i\vec{p}\vec{r}} \vec{r} \Psi_i d^3r \quad (16)$$

(15)-аас р хувьсагчаар уламжлал авбал:

$$a(\vec{k}, \tau) = \frac{d}{d\vec{p}} \Psi_i(\vec{p}) = \frac{-4(\vec{k} + \vec{A}(t))2\sqrt{2}}{\pi((\vec{k} + \vec{A}(t))^2 + 1)^3}. \quad (17)$$

илэрхийлэл гарна. Энд

$$\frac{dP}{dEd\Omega} = 2k |a(\vec{k}, \tau)|^2. \quad (18)$$

В. КУЛОН-ВОЛКОВЫН ОЙРОЛЦООЛОЛ (КВО)

Цөмийн үүсгэх цахилгаан орон нь лазерын цахилгаан оронтой ойролцоо $\left| \frac{Z}{r} \right| \approx |\vec{r} \cdot \vec{E}(t)|$ үед (1) тэгшитгэлийн шийдийг Кулон-Волковын долгион функцээр илэрхийлж болно. Кулон-Волковын долгион функц [17].

$$\Psi_{\vec{k}}(\vec{r}, t) = \Phi_{\vec{k}}(\vec{r}) \Psi_V(\vec{k}, \vec{r}, t) \quad (19)$$

$\Psi_V(\vec{k}, \vec{r}, t)$ - Волковын долгионы функц, $\Phi_{\vec{k}}(\vec{r})$ - Кулоны үржигдэхүүн

$$\Phi_{\vec{k}}(\vec{r}) = N_k F\left(-\frac{i}{k}, 1, -ikr - i\vec{k} \cdot \vec{r}\right) \quad (20)$$

$$N_k = (2\pi)^{-3/2} \exp\left(\frac{\pi}{2k}\right) \Gamma\left(1 + \frac{i}{k}\right) \text{ нормчлолын}$$

коэффициент. Кулон – Волковын ойроцоололд иончлолын амплитуд:

$$a^{CV}(t) = -iN_k N_i \int_0^t dt \exp\left\{i(\varepsilon_f - \varepsilon_i)t + i \int_0^t dt' \vec{k} \cdot \vec{A}(t')\right\} \vec{E}(t) \cdot \int d^3r e^{-i\vec{r}} e^{i(\vec{k} + \vec{A}(t))\vec{r}} F\left(-\frac{i}{k}, 1, -ikr - i\vec{k} \cdot \vec{r}\right) \quad (21)$$

$N_i = \frac{1}{\sqrt{\pi}}$ эхний төлөвийн нормчлолын коэффициент. Матрицын элементэд орж буй координатын интеграл нь

$$\vec{I}_0(\vec{k}, t) = \int d^3r e^{i(\vec{k} + \vec{A}(t))\vec{r} - Zr} F\left(-\frac{i}{k}, 1, -ikr - i\vec{k} \cdot \vec{r}\right) \quad (22)$$

(22)-т дараах интегралыг ашиглавал: [18]

$$K_0 = \int d^3r \cdot \frac{1}{r} e^{i\vec{q}\vec{r} - i\lambda r} F(i a_1; 1; i p_1 r - i \vec{p}_1 \vec{r}) F(i a_2; 1; i p_2 r - i \vec{p}_2 \vec{r}) = \frac{2\pi}{\alpha} e^{-\pi a_1} \left(\frac{\alpha}{\gamma}\right)^{i a_1} \left(\frac{\alpha}{\alpha + \beta}\right)^{i a_2} F\left(i a_1; i a_2; 1; \frac{\beta\gamma - \alpha\delta}{\gamma(\alpha + \beta)}\right) \quad (23)$$

дээрх интеграл нь $a_1 = 0$ үед гарч ирнэ.

$$K_0 = \int d^3r \cdot \frac{1}{r} e^{i\vec{q}\vec{r} - i\lambda r} F(i a_2; 1; i p_2 r - i \vec{p}_2 \vec{r}) = \frac{2\pi}{\alpha} \left(\frac{\alpha}{\alpha + \beta}\right)^{i a_2} F\left(0; i a_2; 1; \frac{\beta\gamma - \alpha\delta}{\gamma(\alpha + \beta)}\right) \quad (24)$$

$$\text{Энд } \alpha = \frac{1}{2}(q^2 + \lambda^2), \quad \beta = \vec{p}_2 \vec{q} - i\lambda p_2, \quad a_2 = \frac{i}{k}$$

$$K_0 = \frac{2\pi}{\alpha'} \left(\frac{\alpha'}{\alpha' + \beta}\right)^{i a_2} = \frac{2\pi}{\frac{1}{2}(q^2 + \lambda^2)} \cdot \left(\frac{\frac{1}{2}(q^2 + \lambda^2)}{\frac{1}{2}(q^2 + \lambda^2) + \vec{p}_2 \vec{q} - i\lambda p_2}\right)^{i a_2} \quad (25)$$

(25)-ыг (22)- тай харьцуулбал:

$$\vec{I}_0(\vec{k}, t) = -\frac{\partial^2 K_0}{\partial \lambda \partial \vec{q}} \quad (26)$$


болно. Эдгээр уламжлалыг авч (21)-т орлуулахад Кулон-Волковын ойролцоололоор амплитуд:

иончлолын

$$a^{CV}(\vec{k}, t) = -\frac{32\pi(2i\vec{k}(i + \vec{k})^2 + 2(1 + i\vec{k})(i + \vec{k})\vec{A}(t) + (-4 + 2i \cdot \vec{k})\vec{A}(t)^2 - 2i\vec{A}(t)^3)}{(i + \vec{k} - \vec{A}(t))^2(1 + \vec{k}^2 + 2\vec{k} \cdot \vec{A}(t) + \vec{A}(t)^2)^3} \quad (27)$$


III. ҮР ДҮН

Атомыг $I = 10^{15}$ Вт/см² эрчимтэй, 4циклтэй, 0.3 а.н давтамжтай 2.026 фемтосекундын лазерын пульсээр иончлох процессыг Кулоны долгион функцээр бааз хийсэн дискрет хувьсагчаар илэрхийлэх аргаар хугацаанаас хамаарсан Шредингерийн тэгшитгэлийг гурван хэмжээст Математика програмаар тооцоолоход дараах үр гарлаа. Үр дүнгээс харахад Дискрет хувьсагчийн арга нь маш сайн үр дүн өгсөн буюу [13] ажлын үр дүнтэй тохирч байна. Хүчтэй орны ба Кулон- Волковын ойролцоолол бага энергийн мужид зөрүүтэй гарсан. Дээрх гурван арга их энергийн мужид дөхөлт сайтай байна.



Зураг 1. Иончлолын магадлалын нягт электроны энергиэс хамаарах хамаарал (шулуун-ХХО, тасархай шугам-КВО, цэг-ДХА).

Мөн лазерын пульсын уртыг 6 дахин нэмэгдүүлсэн 12.05 фемтосекундын пульсээр устөрөгчийн атомын үндсэн төлөвийг иончлох магадлалын нягтыг хүчтэй орны ба Кулон-Волковын ойролцооллоор бодсон үр дүнгүүдийг харьцуулахад их энергитэй электрон сугаран гарах үед дээрх ойролцоолууд тохирч байна.



Зураг 2. Иончлолын магадлалын нягт электроны энергиэс хамаарах (ХХО, КВО).

ХХО ба КВО аргуудаар тооцоолсон иончлолын магадлалын нягтыг тооцоолсон үр дүнгүүдийг харьцуулахад олон фотоны зэрэг шингээх магадлал нь жигд бууралттай байна.

IV. ДҮГНЭЛТ

Лазерын пульсээр атомыг иончлох бодлогод Кулоны долгион функцээр бааз хийсэн дискрет хувьсагчаар илэрхийлэх аргаар хугацаанаас хамаарсан Шредингерийн тэгшитгэлийг гурван хэмжээст тохиолдолд бодлоо. Дискрет хувьсагчийн арга нь бусад аргуудтай харьцуулахад Шредингерийн тэгшитгэл бодох нарийчлал сайтай арга болох нь харагдлаа. Бидний тооцоо Alexei N. Grum-Grzhimailo [13] нарын матриц-итерацийн аргаар бодсон үр дүнтэй харьцуулахад тохирч байна. Хүчтэй орны ба Кулон-Волковын ойролцоо аргууд нь

их энергитэй мужид тооцоолол хийхэд тохиромжтой байна.

V. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] J.L.Hansen, L.Holmegaard, J.H.Nielsen, H.Stapelfeldt and L.B.Madsen, J. Phys. B: At. Mol. Opt. Phys. **45**, 015101 (2012).
- [2] C.D.Lin, T.Morishita, R.Lucchese, A-T. Le, Z.Chen, J. Phys. B: At. Mol. Opt. Phys. **43**, 122001(2010).
- [3] Xiao-Min Tong, Shih-I Chu, Chemical physics **217** (1997), 119-130
- [4] L.A.Collins, A.L.Merts, J.Opt.Soc.Am. **B7**, 647 (1990).
- [5] Xiaoxin Zhou and C.D.Lin, Phys.Rev.Lett.**64**, 862 (1990).
- [6] Q.Su, J.H.Eberly and J.Javanainen, Phys. Rev. Lett. **64**, 862 (1990).
- [7] V.C.Reed, K.Burnett, Phys. Rev. A**42**, 3152 (1990).
- [8] J.H.Eberly, J.Javanainen and Q.Su, J. Opt. Soc. Am. **B6**, 1289 (1989).
- [9] B.I.Schneider, Phys. Rev. A, **55**, 3417 (1997).
- [10] M.Gavrila, J.Shertzer, Phys. Rev. A, **53**, 3431 (1996).
- [11] Jian Zhang, Lambropoulos, Phys. Rev. Lett., **77**, 2186 (1996).
- [12] Л.Д.Ландау, Е.М. Лифшиц, Физика III, Москва (1974).
- [13] Alexei N. Grum-Grzhimailo, Brant Abeln, Klaus Bartschat and Daniel Weflen, Phys. Rev. A., **81**, 043408 (2010).
- [14] Liang-You Peng, and Anthony F Starace, J. Chem. Phys., **125**, 154311(2006).
- [15] Liang-You Peng, and Anthony F. Starace, 2008. arXiv:physics/0604181v1/
- [16] Keldysh.L.V (1965) "Ionization in the field of a strong electromagnetic wave" Soviet physics JETP, volume20, Number1.
- [17] Jain M and Tzoar N (1978) Phys. Rev. A, **18**, 538-45.
- [18] Nordsieck.A, (1953) "Reduction of an Integral in the Theory of Bremsstrahlung" Physical review volume 93, number 4.

Судалгааны реакторыг дэмжих үндэсний дэд бүтцэд хийсэн урьдчилсан үнэлгээ

Г.Цэмбэлмаа^{1,*}, Бя.Мөнхбат^{1,2}, Н.Норов^{1,2}

¹Цөмийн физикийн судалгааны төв, Монгол улсын их сургууль

²Хэрэглээний шинжлэх ухааны инженерчлэлийн сургууль, Монгол улсын их сургууль

Энэ судалгааны ажлын зорилго нь Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн арга зүйд тулгуурлан Монголын цөмийн анхны судалгааны реакторын төслийг дэмжих үндэсний цөмийн дэд бүтцийн зарим асуудалд өөрийн үнэлгээг хийж, Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн шаардлагуудтай харьцуулалт хийж цаашид хийгдэх шаардлагатай ажлуудын талаар зарим дүгнэлтүүдийг гаргасан.

I. ОРШИЛ

Монгол Улсын төрөөс цөмийн энерги, цацраг идэвхит ашигт малтмал ашиглах талаар баримтлах төрийн бодлого болон Цөмийн энергийн хуулийг 2009 онд УИХ-аар соёрхон баталсан.[1,2]. Энэхүү төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрүүдэд ирээдүйн өсөн нэмэгдэх эрчим хүчийг хангах эх үүсвэрүүдийн нэг нь цөмийн эрчим хүч байх болно гэж заасан. Эдгээр нь цөмийн энергийг ашиглах эрх зүйн үндэс болж байна. Цөмийн энерги ашиглаж эхлэх гэж байгаа улсад тулгардаг томоохон асуудлын нэг бол хүний нөөцийн асуудал байдаг. Ихэнхи орны туршлагаас харахад цөмийн эрчим хүчний хүний нөөцийг бэхжүүлэх гол арга зам нь судалгааны реактор барьж байгуулах юм. Үүссэн нөхцөл байдалд тулгуурлан судалгааны реактортой болох шаардлага гарч ирсэн. Үүнээс гадна эрүүл мэнд, хөдөө аж ахуй гэх мэт бусад салбарт хэрэглэдэг бүх цацраг идэвхит изотопоо импортоор авдаг манай улсын хувьд судалгааны реакторд эдгээр изотопуудаа өөртөө үйлдвэрлэх боломж бүрдэх юм. Эдгээр хэрэгцээнүүддээ тулгуурлан манай улс судалгааны реактортой болох төсөл эхлүүлэхээр төлөвлөж байна. Энэ төслийн зорилго нь изотопын дотоод хэрэгцээг хангах, цөмийн шинжлэх ухаан ба технологийн үндэсний чадамжийг нэмэгдүүлэх мөн үндэсний хүний нөөцийн хөгжилд дэмжлэг үзүүлэх юм. Судалгааны реакторын төсөл нь хууль эрх зүйн тогтолцоо, хяналтын тогтолцоо, хүний нөөц үндэсний бодлого гэх мэт цөмийн дэд бүтцүүдээр үндэсний хэмжээнд дэмжигдэх ёстой. Судалгааны реакторын дэд бүтцийн одоогийн төлөв байдал ба хөгжлийг Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (ОУАЭА)-ийн гаргасан замын зураглалын дагуу 3 үе шатад хуваах ба үе шат бүрд 19 асуудлыг нарийвчлан хэлэлцдэг[3,4]. Төслийг эхлүүлэхээс өмнө одоогийн нөхцөл байдлаа үнэлж, ОУАЭА-ийн

ерөнхий шаардлагуудтай харьцуулж тэдгээрийн хоорондын зөрүүг тогтоон цаашид дутагдалтай байгаа асуудлуудаа тодорхой болгодог. Энэхүү ажлаар Монголд анхны судалгааны реакторын төсөл эхлүүлэхэд зориулан дэд бүтцийн зарим асуудлын өөрийн үнэлгээг ОУАЭА-ийн гаргасан арга зүйн дагуу боловсруулсан үр дүнг үзүүлнэ. Үр дүнд замын зураглалын 1-р үе шат дах одоогийн ерөнхий нөхцөл байдал ба цаашид анхааралдаа авах зарим дүгнэлтүүдийг гаргав.


II. АРГАЗҮЙ

A. Судалгааны реакторын төслийн үе шат ба замын зураглал

Судалгааны реактортой болсноор цөмийн шинжлэх ухаан ба технологийн хөгжилд томоохон ахиц гарах болно. Гэвч анхны судалгааны реактор танилцуулахын тулд барьж байгуулах, үйл ажиллагаа явуулах, ашиглалтаас гаргах үеийн аюулгүй ажиллагаа, хамгаалалт, аюулгүй байдал ба ослын бэлэн байдал зэргийг тусгасан техникийн өргөн салбарыг бататгах үндэсний болон олон улсад хүлээх үүрэг, гэрээг хамрах дэд бүтцийн асуудлаа маш сайн шийдвэрлэх хэрэгтэй. ОУАЭА-аас 2012 онд “Судалгааны реакторын төслийн замын зураглал ба тусгай асуудлууд” цөмийн энергийн цувралын NP-T-5.1 хэвлэн гаргасан[3]. Тус хэвлэлийг судалгааны реакторын хөгжлийн үе шатыг хугацааны интервалаар үзүүлсэн замын зураглал хийхэд гарын авлага болгон ашиглана. Энэхүү хэвлэл нь дэд бүтцийн асуудлын шат бүрдэх хүлээгдэж буй үр дүнгийн нарийвчилсан тодорхойлолтыг багтаасан. 1-р зурагт судалгааны реакторын замыг зураглалыг харуулж байна. Хөгжлийн явц ба биелэлтэд үнэлгээ хийж дараагийн шат руу шилжих шийдвэр гаргахад зориулсан шат бүрийн гүйцэтгэлийг тусгай зураглалаар тэмдэглэнэ.

* Electronic address: tsembelmaa2005@gmail.com

Судалгааны реакторын төслийн 3 шат ба тэдгээрт харгалзах асуудлуудыг 1-р хүснэгтэд дүрслэн харууллаа.



Зураг 1. Судалгааны реакторын замын зураглал.

ХҮСНЭГТ 1. Цөмийн дэд бүтцийн хөгжлийн асуудлууд

Дэд бүтцийн асуудлууд	Замын зураглалын I үе	Замын зураглалын II үе	Замын зураглал III үе
Үндэсний байр суурь	Судалгааны реакторын төслийг хэрэгжүүлэх шийдвэр гарахаас өмнө хэрэгжүүлэх асуудлуудыг хангах нөхцөлүүд	Шийдвэр гарсны дараа судалгааны реактор барихад зориулан бэлтгэл ажлыг хангах нөхцөлүүд	Судалгааны реакторын төслийг хэрэгжилтийг хангах нөхцөлүүд
Цөмийн аюулгүй ажиллагаа			
Менежемент			
Хөрөнгө оруулалт ба санхүү			
Хууль эрх зүйн тогтолцоо			
Аюулгүй байдал			
Хяналтын тогтолцоо			
Цөмийн хамгаалалт			
Ашиглалт			
Хүний нөөцийн хөгжил			
Хэрэглэгч талуудын оролцоо			
Барих газрын судалгаа, сонголт, үнэлгээ			
Байгаль орчны хамгаалал			
Ослын бэлэн байдал, хариу арга хэмжээ			
Цөмийн аюулгүй байдал			
Цөмийн түлшний менежмент			
Цацраг идэвхит хаягдал			
Аж үйлдвэрийн оролцоо			
Худалдан авалт			

В. Өөрийн үнэлгээний аргачлал

Өөрийн үнэлгээ нь цөмийн дэд бүтцийн хөгжлийн дараагийн үе шат руу шилжихэд бэлэн эсэхийг тогтоох анхны алхам болох ба цаашилбал үйл ажиллагаагаа байнга сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. ОУАЭА-аас “Шинэ судалгааны реактор төслийг дэмжихэд зориулсан үндэсний цөмийн дэд бүтцийн үнэлгээ” [5] гэсэн нэр бүхий шинэ гарын авлага гаргаж байгаа. Энэхүү гарын авлага нь үндэсний цөмийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдлыг ерөнхий шаардлагуудтай харьцуулан тэдгээртэй үл нийцэх зөрүүг тогтоож цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно.

Үнэлгээ хийх дараалал

Энэхүү өөрийн үнэлгээгээр цөмийн дэд бүтцийн зарим асуудлыг авч хэлэлцэн өнөөгийн статусын зураглал ба үндэсний дэд бүтцийн хөгжлийн явцыг харуулах болно. Өөрийн үнэлгээг хэзээ ч хийж болох ба бид энэ удаа 1-р үе эхлэл үеийн үнэлгээг хийхээр төлөвлөсөн.

- 1-р шатны нөхцөлүүдийн дагуу судалгааны реакторын дэд бүтцийн хөгжлийн статусыг үнэлэх,
- Цаашид анхаарал хандуулах шаардлага бүхий ерөнхий шаардлагуудтай үл нийцэх зөрүүг тодорхойлох,
- Ерөнхий шаардлагуудтай нийцэх санал зөвлөмж гаргах

Үнэлгээний явц

Дэд бүтцийн асуудал бүр нэг ба түүнээс дээш нөхцөлүүдээс бүрдэх ба эдгээр нөхцөлүүд нь тохирох нотлох баримтуудаар батлагдана. Нотлох баримтуудад хууль, зарлиг, албан гэрээ, тайлан, уулзалтын тэмдэглэл, харилцаа холбоо, яриа ба илтгэл, хурал оролцох, зөвлөгөө, байгуулгын ба ажлын тодорхойлол зэрэг багтана. Үр дүн нь дэд бүтцийн асуудал бүрийн нөхцөл шалгуурийг хангах өөрийн үнэлгээний үр дүн ба тайлбарыг нэгтгэсэн хүснэгтээр илэрхийлэгдэнэ. 2-р хүснэгтэд үнэлгээ хийх зааврын жишээг харууллаа. Нотлох баримтуудад үндэслэн үр дүнг гаргаж, цаашид арга хэмжээ авах хэрэгтэй эсэхийг тогтооно.

ХҮСНЭГТ 2. Өөрийн үнэлгээ хийх загвар

Үндэсний байр суурь	I-Үе шат	
СРТХК ба ҮМТБ үүсгэн байгуулагдсан, бие бүрэлдэхүүнтэй, эрх мэдэлтэй, санхүүжилттэй байх		
Үнэлгээний үндэслэл	Нотолгоо	Ажиглалт
Судалгааны реакторийн хөтөлбөрийг тууштай хэрэгжүүлэхийн тулд шийдвэр гаргахтай холбоотой бүх асуудлыг цогцоор нь үнэлж дүгнэх үйл ажиллагааны тодорхой цар хүрээтэй байна.		
Зохих хэмжээний санхүүжилттэй (шаардлагатай бол гадны мэргэжилтэнд зориулсан нэмэлт санхүүжилтыг багтаасан), тодорхой тооны ажилтан, мэргэжилтнээс бүрдсэн байна.		
Үнэлгээ:		
СРТХК-Судалгааны реакторын төсөл хэрэгжүүлэх комисс ҮМТБ-Үнэлгээ, маркетинг, төслийн баг	ЦФСТ- Цөмийн физикийн судалгааны төв ЦЭК- Цөмийн энергийн комисс	

Үнэлгээний ерөнхий явц ба тодорхой чиглэлүүдэд зориулан нөхцөл бүрийн статус дараах байдлаар илэрхийлэгдэнэ. Эдгээр нь:

- Маш их үйл ажиллагаа шаардлагатай
- Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай
- Үйл ажиллагаа шаардлагагүй

III. МОНГОЛЫН ЦӨМИЙН ДЭД БҮТЦИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**А. Үндэсний байр суурь**

Судалгааны реакторд урт хугацааны үндэсний ба олон улсын үүрэг хариуцлага шаардлагатай.

Тиймээс үндэсний байр суурийн асуудал судалгааны реакторын төсөл хэрэгжүүлэхэд маш чухал. СРТХК ба ҮМТБ-ийг засгийн газрын дэмжлэгтэйгээр байгуулах ёстой. Одоогоор монголд СРТХК ба ҮМТБ байгуулагдаагүй боловч тус ажлын хэсгүүдийг байгуулах санал дэвшигдэж хэлэлцэх шатандаа явж байгаа болохыг 3-р хүснэгтээс харагдаж байна.

ХҮСНЭГТ 3. Үндэсний байр суурь

Нөхцөлүүд	Үнэлгээний статус	Ажиглалт	Цаашид анхаарлаа хандуулах
1.1. СРТХК ба УМТБ үүсгэн байгуулагдсан, бие бүрэлдэхүүнтэй, эрх мэдэлтэй, санхүүжилттэй байх	Маш их үйл ажиллагаа шаардлагатай.	СРТХК ба УМТБ-ийг байгуулах саналыг ЦФСТ-өөс ЦЕК-д гаргасан.	СР-ийн төсөл хэрэгжүүлэх ба үнэлгээ, маркетинг, төслийн багийг үүсгэх байгуулах
1.2. Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, хамгаалал ба үл дэлгэрүүлэх гэсэн ойлголтуудыг засгийн газрын юмуу түүний агентлагуудын түвшинд хүлээн зөвшөөрсөн байх	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	Цөмийн энергийн хууль батлагдсан. Зарим олон улсын гэрээ, конвенцэд нэгдсэн. Судалгааны ба эрчим хүчний гэх мэт цөмийн төхөөрөмжүүдтэй холбоотой аюулгүй байдал стандарт, дүрэм журамыг төслийн хугацаанд хөгжүүлэх хэрэгтэй.	Холбогдох байгууллуудад аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, хамгаалал зэргийн соёл ба менежементийн төлөвшүүлэх бодлого ба стратеги төлөвлөгөө
1.3. Олон улсын Цөмийн Аюулгүй Байдлын Дэглэмийг таньж ойлгон, түүнд оролцоход тавигдах шаардлагууд	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	Судалгааны реакторын аюулгүй байдлын дүрмийг батлуулах санал дэвшигдсэн.	Шаардлагатай олон улсын гэрээ конвенцуудад цаг тухайд нь нэгдэх
1.4. СР-ийн төсөл боловсруулахад урьдчилсан стратеги төлөвлөгөө шаардлагатай ба шаардагдах үүрэг даалгаврыг ойлгосон байх	Маш их үйл ажиллагаа шаардлагатай.	СР-ийн төсөл боловсруулах урьдчилсан стратеги төлөвлөгөө боловсруулахад ЦЕК-ийн дэмжлэг маш чухал.	ОУАЕА-ийн зөвлөгөөний дагуу судалгааны реакторын урьдчилсан стратеги төлөвлөгөө ба үндэслэлийг боловсруулах
1.5. Засгийн газар хоорондын шаарлагатай гэрээ хэлэлцээрүүд тодорхой болсон байх.	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	ЦЕК ба РОСАТОМ-ийн хооронд судалгааны реакторын төслийн талаарх анхны санамж бичиг хийгдсэн.	Судалгааны реактор ба хүний нөөцтэй холбоотой гэрээ ба санамж бичгийг тодорхой болгож, хэрэгжилтэнд анхаарах

В. Хууль эрх зүйн тогтолцоо

Хууль эрх зүйн тогтолцоог хангах шаардлагуудыг замын зураглалын 1-р үе шатад засгийн газар, агентлагууд ба холбогдох бусад байгууллагуудтай хэлэлцэж тохиролцох хэрэгтэй. Монголд одоогийн байдлаар цацраг идэвхит үүсгүүрийн хяналтын хууль эрх зүйн тогтолцоо шаардлагатай түвшинд бүрдсэн.

Иймд цөмийн тоног төхөөрөмжтэй холбоотой зарим өөрчлөлтийг хийх шаардлагатай. 4-р хүснэгтэд хууль эрх зүйн тогтолцоог үнэлсэн үнэлгээний товч үр дүнг харууллаа. Үр дүнгээс харахад нилээд хэдэн олон улсын гэрээ, конвенци, дүрэм журмууд хэлэлцэх шатандаа явж байна. Бүх үйл ажиллагаа цөмийн энергийн хуулиар зохицуулагдах ёстой.

ХҮСНЭГТ 4. Хууль эрх зүйн тогтолцоо

Нөхцөлүүд	Үнэлгээний статус	Ажиглалт	Цаашид анхаарлаа хандуулах
2.1. СРТХК-ийн тогтоосон олон улсын эрх зүйн баримт бичиг, тэдгээрийг засгийн газартай зөвшилцөж, төлөвлөн дагаж мөрдөх	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	Ихэнхи шаардлагатай гэрээ конвенцуудад нэгдсэн ба зарим нь засгийн газраар хэлэлцэх түвшинд явж байгаа. Судалгааны реакторын аюулгүй байдлын дүрмийг батлуулахаар ЦЕК-д хүсэлт гаргасан.	Дараах бичиг баримтуудыг батлуулахад анхаарлаа хандуулах: Цөмийн аюулгүй байдал, ашигласан түлшний болон цацраг идэвхит хаягдлын менежементын аюулгүй байдал, цөмийн материалын биет хамгаалалтын тухай конвенци, бага хэмжээний цөмийн материалын шинэчлэсэн протокол.

2.2. Засгийн газрын цөмийн тухай хууль тогтоомжийг батлан гаргах төлөвлөгөө.	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	ЦЕК холбогдох байгууллагуудтай хамтран цөмийн энергийн хуулийг батлуулсан ба цөмийн болон цацрагийн аюулгүй байдал, хамгаалалтын бодлого ба дүрмийг боловсруулж байгаа.	Цаашид боловсруулах баримт бичгүүдээ цөмийн төхөөрөмжийн талаарх заалтуудыг тодорхой оруулж өгөх.
2.3. Одоогийн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах Засгийн газрын төлөвлөгөө.	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	Одоогийн хууль, дүрэм журмууд ихэвчлэн цацраг идэвхит ашигт малтмал ба цацраг идэвхит изотопод чиглэсэн хандлагатай байгаа тул зарим нэмэлт өөрчлөлт шаардлагатай.	Төслийн ажлийг эхлүүлэхээс өмнө зохих нэмэлт өөрчлөлтийг хийх хэрэгтэй.
2.4. Хууль эрх зүйн хүрээний талаар оролцогч талуудтай зөвлөлдөх.	Маш их үйл ажиллагаа шаардлагатай.	Оролцогч талуудыг эцэслэн шийдээгүй байгаа ба тэдэнтэй Хууль эрх зүйн хүрээний талаар албан ёсоор зөвлөлдөөгүй байгаа.	Оролцогч талуудын эрх үүргийг хуулийн хүрээнд тодорхой болгох.

С. Хяналтын тогтолцоо

юм. 5-р хүснэгтэд хяналтын тогтолцооны үр дүнг харууллаа.

Хяналтын тогтолцооны үндсэн хэсэг нь тусгаар, өрсөлдөх чадвар бүхий хяналтын байгууллага

ХҮСНЭГТ 5. Хяналтын тогтолцоо

Нөхцөлүүд	Үнэлгээний статус	Ажиглалт	Цаашид анхаарлаа хандуулах
3.1. СРТХК-ын хяналтын тогтолцооны хэрэгцээ шаардлага болоод хамрах хүрээг судлаж харгалзан тусгай төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	Одоогоор техникийн зөвлөх байгуулга байхгүй, мөн зөвшөөрөл олгох, хяналт шалгалт, дүрэм журам хэрэгжүүлэх баримт бичгүүдэд цөмийн төхөөрөмжийн тухай заалт бараг ороогүй.	Хяналтын байгууллагаас гадна техникийн талаас дэмжигч байгууллага байгуулах шаардлагатай. Хяналтын байгуулгынхаа хүчин чадал боломж бололцоо, үйл ажиллагааны чиглэл, хариуцлагыг тодорхой болгож хүчин чадлаа нэмэгдүүлэхэд анхаарах.

Д. Судалгааны реакторын ашиглалт

бүдүүвч байдлаар гаргасан боловч нарийвчилсан хэрэглээний жагсаалт ба оролцогчдыг эцсийн байдлаар тогтоогүй болох нь харагдаж байна.

6-р хүснэгтэд судалгааны реакторын ашиглалтын үнэлгээг харууллаа. Манай улсын хувьд судалгааны реакторын ашиглалтаа

ХҮСНЭГТ 6. Судалгааны реакторын ашиглалт

Нөхцөлүүд	Үнэлгээний статус	Ажиглалт	Цаашид анхаарлаа хандуулах
4.1. Оролцогч талуудыг тогтоох, зөвшилцөх.	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	Оролцогч талуудын тоймлон гаргасан боловч нарийвчлалсан жагсаалт гараагүй.	Цаашид оролцогч талуудыг эцэслэн шийдэж, тэдэнтэй албан ёсоор зөвшилцөх.
4.2. Судалгааны реакторын хэрэглээний цар хүрээг судласан байх.	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	Одоогийн шаардлагадаа үндэслэн боломжит хэрэглээг урьдчилсан байдлаар тодорхойлсон.	Судалгааны реакторын хэрэгцээгээ хангах боломжит чадалдаа үнэлгээ хийх.

4.3. Судалгааны реакторын ашиглалтанд оролцогч талуудын байнгын оролцоог тодорхойлох.	Маш их үйл ажиллагаа шаардлагатай.	Энэ талаар одоогоор зөвлөлдөөгүй байна.	4.3. Судалгааны реакторын ашиглалтанд оролцогч талуудын байнгын оролцоог тодорхойлох.
4.4. Бүсийн нутгийн болон олон улсын хамтын ажиллагааг авч үзэх	Маш их үйл ажиллагаа шаардлагатай.	Одоогийн байдлаар бусад улс орнуудтай ашиглалтын асуудлаар хийсэн тодорхой гэрээ хэлэлцээр байхгүй.	Цаашид судалгааны реакторын ашиглалтын талаар бүс нутгийн ба олон улсын түвшиний боломжит оролцогчдыг судлах.
4.5. Урьдчилсан төслийн үнэлгээний тайланг (PPAR) СРТХК-д танилцуулах.	Маш их үйл ажиллагаа шаардлагатай	Урьдчилсан үнэлгээ боловсруулж байгаа ч СРТХКхараахан байгуулагдаагүй байгаа.	СРТХК-ийг даруйхан байгуулах шаардлагатай.
4.6. Судалгааны реактор ба түүний дагалдах төхөөрөмжүүдийн үндэслэл нь СРТХК-оор хүлээн зөвшөөрөгдөх	Маш их үйл ажиллагаа шаардлагатай.	Дагалдах төхөөрөмжүүдийг хэрэглээнд үндэслэн судлаж байна.	Оролцогчдын хэрэгцээг тусгах хэрэгтэй ба хэрэгцээг эцэслэсний дараа тэдгээрийн техникийн үзүүлэлтийг тодорхой болгох хэрэгтэй.
4.7. Тогтвортой ашиглалтын талаар судалгааны реакторт зориулсан урьдчилсан стратеги төлөвлөгөөнд (PSP) тусгайлан заах	Маш их үйл ажиллагаа шаардлагатай	Одоогоор тодорхой авч үзсэн зүйл байхгүй. Урьдчилсан стратеги төлөвлөгөө нь тоног төхөөрөмж ба багаж хэрэгсэл, мэргэшсэн боловсон хүчин, зэргийг багтаасан байна.	Төхөөрөмжийн тогтвортой ажиллагааны талаар урьдчилсан стратеги төлөвлөгөөнд заавал авч үзэх хэрэгтэй.

Е. Хүний нөөц

7-р хүснэгтэд хүний нөөцийн хөгжлийн үр дүнг харууллаа. МУИС-ийн сургалтын хөтөлбөрийн дагуу цөмийн инженерчлэлийн баклавр магистр докторын түвшний мэргэжилтэнүүдийг жил бүр бэлтгэж байна. Мөн ОХУ, Япон, Солонгос зэрэг орнуудад тодорхой тооны мэргэжилтнүүдийг

бэлтгэж байна. Үр дүнгээс харахад мэргэшсэн боловсон хүчний чадавхийг сайжруулах улсын хэмжээний цогц бодлого шаардлагатай нь харагдаж байна.

Одоо үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд тус бүрдээ өөрсдийн хүний нөөцийн бодлоготой хэдий ч хоорондын нэгдсэн бодлого бүхий хамтын ажиллагаа сул байна.

ХҮСНЭГТ 7. Хүний нөөц хөгжил

Нөхцөлүүд	Үнэлгээний статус	Ажиглалт	Цаашид анхаарлаа хандуулах
5.1. Үндэсний хэмжээнд шаардагдах хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөтэй байх.	Бага зэргийн үйл ажиллагаа шаардлагатай.	Одоогийн байдлаар улсын хэмжээний нэгдсэн бодлого байхгүй цөмийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд тус тусдаа өөрсдийн хүний нөөц дээр тулгуурлах ажиллаж байна.	ЦФСТ цөмийн инженерчлэлийн мэргэжилтнүүдээ мэргэшүүлэх тал дээрх анхаарч цогц сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мөн цаашид хэрэгцээ нэмэгдэнэ гэдгийг анхаарах.
5.2. СР-ын төсөлд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах үндэсний хэмжээний мэдлэг, ур чадварыг ҮМТБ-аас тогтоож, СРТХК- ээр хүлээн зөвшөөрүүлсэн байх.	Маш их үйл ажиллагаа шаардлагатай.	Одоо үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудынхаа хүний нөөцөд хийсэн нэгдсэн үнэлгээ хийх.	Үе шат бүрд шаардагдах хүний нөөцийн үнэлгээг гаргаж, оролцогч байгууллагуудтайгаа хамтран улсын хэмжээнд нэгдсэн бодлогоор хүний нөөцдөө анхаарч, борлуулагч талтай хамтрасан сургалт хөтөлбөр зохион байгуулах.

IV. ДҮГНЭЛТ

Судалгааны реакторын төсөл хэрэгжүүлэх үндэсний байр суурийг бий болгох зорилгоор СРТХК баҮМТБ-ийг үүсгэн байгуулах анхны саналыг Монгол Улсын Их Сургуулийн харьяа ЦФСТ-өөс ЦЭК-д гаргасан.

Монгол Улсын цөмийн энергийн тухай хууль болон дүрэм журмууд голчлон цацраг идэвхит ашигт малтмал ба цацраг идэвхит изотопын зохицуулалтанд зориулагдсан байна. Иймд манай улс цөмийн төхөөрөмж барьж байгуулахын тулд цөмийн хууль эрхзүйн орчноо сайжруулж, тохирох нэмэлт өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай.

Манай улсын цөмийн болон цацрагийн хяналтын тогтолцоо 2015 онд өөрчлөгдөж, үндсэн хяналтын байгууллага нь мэргэжлийн хяналтын ерөнхий газрын харьяа цөмийн ба цацрагийн мэргэжлийн хяналтын хэлтэс болсон. Цөмийн ба цацрагийн мэргэжлийн хяналтын хэлтэс нь цацраг идэвхит үүсгүүрийн зөвшөөрөл, хяналт, дүрэм журам боловсруулах хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэж байна. Одоогоор манай улсад техникийн зөвлөх байгууллага байхгүй, мөн зөвшөөрөл олгох, хяналт шалгалт хийх, дүрэм журам хэрэгжүүлэх баримт бичгүүдэд цөмийн төхөөрөмжийн тухай заалт ороогүй байгаа ба цаашид зарим нэмэлт өөрчлөлт хийхдээ энэ тал дээр анхаарах хэрэгтэй.

Урьдчилсан судалгаанаас харахад манай улсад судалгааны реакторыг сургалт судалгаа, эрүүл мэнд, хөдөө аж ахуй гэх мэт салбаруудад хэрэглэх тооцоо гаргаж оролцогч байгууллагуудыг тогтоох ажил хийгдэж байгаа ба эцэслэн шийдэгдээгүй байна. Зарим тодорхой болсон оролцогч байгууллагууд тэдгээрийн хэрэгцээнд үндэслэн дагалдах төхөөрөмжүүдийн судалгаа хийгдэж байна. Урьдчилсан стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа тоног төхөөрөмж ба багаж хэрэгсэл, мэргэшсэн боловсон хүчин, төслийн хэрэгжилтийн явц зэргийг багтаасан тогтвортой ажиллагааны асуулдлыг заавал авч үзэх хэрэгтэй.

ТАЛАРХАЛ

Энэхүү ажил нь Солонгос цөмийн аюулгүй байдлын институт (KINS) ба Солонгосын шинжлэх ухаан, технологийн дэвшилтэд институт (KAIST)-ийн хамтарсан магистрийн хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн болно. Энэхүү ажлыг гүйцэтгэхэд бүх талаар туслаж дэмжин судалгааны ажлыг удирдсан Солонгос цөмийн аюулгүй байдлын институтын реакторын

лицензийн салбарын судалгааны реактор барих төслийн менежер доктор Суанжэй Ким-д гүн талархал илэрхийлье.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- [1] Монгол Улсын төрөөс цацраг идэвхит ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах талаар баримтлах бодлого, УИХ, Улаанбаатар, Монгол Улс, 2009.
- [2] Цөмийн энергийн тухай хууль, УИХ, Улаанбаатар, Монгол Улс, 2009.
- [3] Судалгааны реакторын төслийн тусгай асуудлууд ба замыг зураглал, No. NP-T-5.1, ОУАЭА, Вена, 2012.
- [4] Судалгааны реакторын аюулгүй үйл ажиллагаа, NS-R-4, ОУАЭА, Вена, 2005.
- [5] Шинэ судалгаан реактор төслийг дэмжихэд зориулсан үндэсний цөмийн дэд бүтцийн үнэлгээ, ОУАЭА, Вена, 2016, (draft).

Бороон дахь микродолгионы унтралын шинж төрх

М. Батпүрэв¹, Ж. Нямжав^{2*}

¹Физикийн тэнхим, Шинжлэх Ухааны Сургууль, Монгол Улсын Их Сургууль, Улаанбаатар, Монгол Улс

²Электроник, холбооны инженерчлэлийн тэнхим, Хэрэгээний шинжлэх ухаан, Инженерчлэлийн сургууль, Монгол Улсын их Сургууль, Улаанбаатар, Монгол Улс

Сансарын болон газрын холбооны системд ашиглаж байгаа микродолгионыг унтраадаг сөрөг хүчин зүйлсийн нэг нь бороо юм. Бороо нь микродолгионы хувьд 0.1-ээс 7 хүртэлх мм диаметртэй, орон зайд тархан байрласан усны дуслууд юм. Микродолгионы мужид долгионы урт нь борооны дуслын хэмжээтэй жишихүйц болж ирдэг бөгөөд 30 мм болон түүнээс бага долгионы урттай микродолгионы унтралт мэдэгдэхүйц их, өөрөөр хэлбэл холбооны системийн ажиллагаанд муугаар нөлөөлөхүйц болдог. Бид микродолгионы уртын 3-30 мм (давтамжийн 10-100 ГГц) мужид микродолгионы унтралыг үүсгэж байгаа борооны дуслын сарнил болон шингээлтийг дуслын хэмжээ болон долгионы уртаас хэрхэн хамаарч байгааг Мигийн онолын хүрээнд тооцоо хийж судлав.

I. ОРШИЛ

Микродолгион саадыг тойрон тархах чадвар муу учир түүнийг ашигладаг радио холбооны станцуудыг шууд бие биеэ харахаар байршуулдаг бөгөөд энэ тохиолдолд радио холбооны тасралтгүй найдвартай ажиллагаа цас, бороо, манан, мөндөр, өтгөн үүлшилт, шороон шуурга гэх мэт цаг агаарын үзэгдлээс ихээхэн хамаардаг. Борооны дуслууд шингэн, дуслын хэмжээ нь микродолгионы урттай жишихүйц тул бусад цаг агаарын үзэгдэлтэй харьцуулахад микродолгионыг илүү унтраадаг [1]. Иймд микродолгионы радио холбооны системийн найдвартай тасралтгүй ажиллагааг хангахын тулд микродолгионд борооны үүсгэх унтралыг (цаашид борооны унтрал гэнэ) зайлшгүй тооцох шаардлагатай болдог. Ихэнхи судлаачид микродолгионы борооны унтралын онолын тооцоо хийхдээ сарнил болон шингээлт хоёрын нийлбэрээр илэрхийлэгддэг унтралыг шууд бодсон байдаг [1]. Иймд бид микродолгионы унтралын шинж төрхийг улам тодруулах үүднээс түүний бүрдүүлэгч хэсэг болох борооны дуслын сарнил болон шингээлийг тус тусад нь Мигийн онолоор бодож борооны дуслын хэмжээ болон микродолгионы уртаас хэрхэн хамаарч байгааг судлав.

II. МИКРОДОЛГИОНЫ ТАРХАЛТАНД БОРООНЫ ДУСАЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Бороо нь радио долгионы хувьд агаарт тархан байрласан 0.1-ээс 7 мм хүртэлх диаметртэй усны унаж байгаа дуслууд юм. Унаж байгаа тул агаарын эсэргүүцлийн улмаас дуслын хэмжээ ихсэх тусам хэлбэр нь бөмбөрцөгөөс гажиж

хэвтээ зуйван болдог. Үүнээс гадна дуслууд дусал хоорондын мөргөлдөөн болон салхины нөлөөгөөр хэлбэлзэх хөдөлгөөнд ордог тул нэг ижил эзэлхүүнтэй борооны дуслууд өөр өөр хэлбэртэй болдог [3]. Микродолгионы борооны унтралд маш олон тооны борооны дуслууд оролцдог тул борооны нэг дуслын үүсгэх унтралыг тооцоолохдоо нэг ижил эзэлхүүнтэй дуслын дундаж хэлбэрийг авч үзэхэд хангалттай бөгөөд энэ хэлбэр нь бөмбөрцөгт ойрхон байдаг [4]. Борооны нийт унтрал борооны дусал бүрийн унтрал ба борооны дуслын хэмжээний түгэлтээс хамаардаг. Бид энэ ажлын хүрээнд зөвхөн борооны дуслын унтралыг авч үзлээ. Борооны дуслын үүсгэх микродолгионы унтралын шинж төрхийг судлахдаа борооны дуслыг бөмбөрцөг хэлбэртэй гэж үзэн Мигийн онолыг ашиглав. Борооны дуслууд микродолгионыг тархалтын чиглэлээс нь өөр зүгт сарниулахын зэрэгцээ өөртөө шингээж унтрал үүсгэдэг. Долгионы сарнилын онолд нэг дуслын унтралыг унтралын огтлол гэдэг хэмжигдэхүүнээр илэрхийлдэг бөгөөд энэ нь нэг дуслын унтраасан чадлыг түүнд туссан долгионы эрчимд харьцуулсан харьцаатай тэнцүү байна. Нэг дуслын унтралын огтлолыг дуслын геометр хөндлөн огтлолын талбайд хуваасныг дуслын унтраах чадвар гэдэг. Яг үүнтэй адилаар дуслын сарниулах ба шингээх чадварыг тодорхойлдог бөгөөд эдгээрийн нийлбэр унтраах чадвартай тэнцүү байна. [1,2]

III. БОРООНЫ ДУСЛЫН САРНИЛ

Борооны дусал микродолгионыг зүг бүрт тараан сарниулах ба энэ нь θ сарнилын өнцөгөөс хэрхэн хамаарч байгааг сарнилын

* Electronic address: nyamjav@seas.num.edu.mn

диаграммаар илэрхийлдэг. Сарнилын диаграммыг сарнилын хавтгай (сарнилын өнцөгийг агуулсан) болон түүнд перпендикуляр хавтгай дээр байгуулдаг бөгөөд энэ нь сарнилын далайцын функц гэж нэрлэгддэг $S_2(\theta)$ ба $S_1(\theta)$ -ийн квадратаар харгалзан илэрхийлэгдэнэ. Эдгээр сарнилын функц дараах хэлбэртэй байна [2]

$$\begin{aligned} S_1(\theta) &= \sum_{n=1}^{\infty} \frac{(2n+1)}{n(n+1)} \left\{ a_n \frac{P_n(\cos(\theta))}{\sin(\theta)} + b_n \frac{dP_n(\cos(\theta))}{d\theta} \right\} \\ S_2(\theta) &= \sum_{n=1}^{\infty} \frac{(2n+1)}{n(n+1)} \left\{ a_n \frac{dP_n(\cos(\theta))}{d\theta} + b_n \frac{P_n(\cos(\theta))}{\sin(\theta)} \right\} \end{aligned} \quad (1)$$

энд θ – сарнилын өнцөг. P_n – Лежандрийн өргөтгөсөн олон гишүүнт ба a_n , b_n – Мигийн коэффициент бөгөөд үүнийг Matlab орчинд програмчлахад дөхөмтэй, матриц байдлаар

$$\begin{bmatrix} a_{11} & a_{12} \\ a_{21} & a_{22} \end{bmatrix} = \begin{bmatrix} \psi_{n-1}(q) & -\psi_n(q) \\ \zeta_{n-1}(q) & -\zeta_n(q) \end{bmatrix} * \begin{bmatrix} 1 & 1 \\ n+m\xi_n & n+\frac{\xi_n}{m} \end{bmatrix} \quad (2)$$

$$a_n = \frac{a_{11}}{a_{21}}; \quad b_n = \frac{a_{12}}{a_{22}}$$

гэж бичиж болно. Энд ψ_n ба ζ_n – харгалзан Риккати-Бесселийн ба Риккати-Нейманы функц, m – усны хугарлын илтгэгч, $q = \pi D / \lambda$ – борооны дуслын хэмжээний параметр, D – борооны дуслын диаметр ба λ – микродолгионы урт, $\xi_n = \psi'_n(mq) / \psi_n(mq)$ болно.

Микродолгионы мужид усны хугарлын илтгэгчийг илэрхийлдэг хэд хэдэн загвар байдаг бөгөөд бид Рейгийн загварыг ашиглав [5].

$$m = \sqrt{\varepsilon(\lambda, t^0)}; \quad \varepsilon(\lambda, t^0) = \varepsilon_0 + \frac{\varepsilon_s(t^0) - \varepsilon_0}{1 + i \frac{c}{\lambda \tau(t^0)}} \quad (3)$$


$$\varepsilon_0 = 5.5$$

$$\varepsilon_s(t^0) = 88.2 - 0.408 t^0 + 0.0008 t^{0^2}$$

$$\tau(t^0) = 8.395 + 0.4632 t^0 + 0.0051708 t^{0^2}$$

Бид борооны дуслын сарнилын диаграммыг 3-30 мм (100-10 ГГц давтамжийн) долгионы уртын мужид бодож Зураг 1-д харуулав. Сарнилын хавтгай дээрх сарнилын диаграммыг улаан өнгөөр, түүнд перпендикуляр хавтгай дээрх сарнилын диаграммыг хөх өнгөөр харуулав.

Сарнилын хавтгайд хэвтээ наймын тоотой төстэй түүнд перпендикуляр хавтгайд дугуй хэлбэртэй сарнилын диаграмм нь Релейн буюу диполийн сарнил болохыг харуулдаг.



Зураг 1. Борооны дуслын сарнилын диаграмм.


Зураг 1-ээс харахад дуслын хэмжээ долгионы уртаас олон дахин бага ($D < 1$ мм) мужид цэвэр диполийн буюу Релейн сарнил болж байгаа нь харагдаж байна. Долгионы уртын $15 < \lambda < 30$ мм мужид дуслын хэмжээ томрох тусам сарнилын диаграмм эхлээд гэдрэг чиглэлд (тархалтын эсрэг чиглэлд) дараа нь шууд чиглэлд илүү цүлхийж байна. Гэдрэг чиглэлд цүлхийсэн хэсэгт диэлектрик резонансийн шингээлт ажиглагдаж байгаа нь дуслын шингээх чадварын тооцооноос харагдсан болно. Харин долгионы урт үүнээс цааш бага болох $10 > \lambda > 3$ мм мужид дуслын хэмжээ томрох тусам туссан долгион шууд чиглэлдээ сарних нь ихсэж улмаар хоёр хавтгай дээрх долгионы сарнил адилхан болж байна. Үүнийг Мигийн үзэгдэл гэж нэрлэдэг.

Сарнилын өнцөгийн 0° (шууд) болон 180° (гэдрэг) чиглэл дэх дуслын сарниулах чадварыг

$$Q_{\text{шүүд}} = \frac{2}{q^2} \sum_{n=1}^{\infty} (2n+1) (|a_n|^2 + |b_n|^2) \quad (4)$$


$$Q_{\text{гэдрэг}} = \frac{1}{q^2} \left| \sum_{n=1}^{\infty} (2n+1) (-1)^n (a_n - b_n) \right|^2$$

томъёогоор бодож зураг 2 ба 3-д харуулав.



Зураг 2. Борооны дусал микродолгионыг шууд чиглэлд сарниулах чадвар.

Эндээс харахад борооны дуслын шууд чиглэлд сарниулах чадвар долгионы урт бага байх тусам дуслын хэмжээнээс хамаарч хурдан өсч тогтворжсон утгадаа бага зэрэг хэлбэлзэн дөхөж байна.



Зураг 3. Борооны дусал микродолгионыг гэдрэг чиглэлд сарниулах чадвар.

Харин борооны дусал микродолгионыг гэдрэг чиглэлд сарниулах чадвар долгионы урт бага байх тусам дуслын хэмжээнээс хамаарч маш хурдан өсөөд эргээд хурдан буурч хэлбэлзэж байна. Өөрөөр хэлбэл борооны гэдрэг сарнил борооны дуслыг хэмжээг сонгож 'хардаг' байна. Иймд радарын мэдээллээс борооны дуслын хэмжээг үнэлэхдээ үүнийг зайлшгүй тооцох шаардлагатай.


IV. БОРООНЫ ДУСЛЫН ШИНГЭЭЛТ

Борооны дуслын микродолгионыг шингээх чадварыг унтраах чадвараас сарниулах чадварыг хасаж олж болно.[2] Дуслын унтраах чадварыг

$$Q_{\text{унт}} = \frac{2}{q^2} \sum_{n=1}^{\infty} (2n+1) \text{Re}(a_n + b_n) \quad (5)$$

$$Q_{\text{шинг}} = Q_{\text{унт}} - Q_{\text{сарн}}$$

Борооны дуслын микродолгионыг шингээх чадварыг 3-30 мм (100-10 ГГц давтамжийн) долгионы уртын мужид дуслын хэмжээнээс хамааруулан бодож Зураг 4-д харуулав.




Зураг 4. Борооны дусал микродолгионыг шингээх чадвар.

Энд долгионы уртын (15-30) мм буюу усны хугарлын илтгэгчийн бодит хэсэг их байх мужид диэлектрик резонансийн шингээлт илэрч байна. Энэ мужид борооны дусал доторхи дотоод бүрэн ойлтын коэффициент их болж улмаар $q \cdot \text{Re}\{m\} = \pi$ буюу $D = \lambda / \pi \text{Re}\{m\}$ нөхцлийг хангах диаметртай дуслын дотор микродолгионы зогсонги долгион үүсэх нөхцөл бүрдэж дусалд долгион

шингээгдэнэ. Хэрэв хугарлын илтгэгч цэвэр бодит бол зогсонги долгион огт унтрахгүй маш хүчтэй резонансын шингээлт үүсгэдэг. Харин усны хувьд түүний дамжууллаас (хугарлын илтгэгчийн хуурмаг хэсгээс) болж зогсонги долгион унтарсанаар резонансын шингээлт хүчтэй биш илэрч байна. Ерөнхийдээ микродолгионы урт багасах тусам дуслын хэмжээнээс хамааран хурдан өсч хамгийн их утгадаа хүрээд бууран бага зэрэг хэлбэлзээд тогтворжиж байна.

V. БОРООНЫ ДУСЛЫН УНТРАЛ

Борооны дуслын микродолгионыг унтраах чадвар шууд сарниулах ба шингээх чадварын нийлбэртэй тэнцүү байдаг бөгөөд түүнийг Зураг 5-д харуулав.



Зураг 5. Борооны дусал микродолгионыг унтраах чадвар.

Борооны унтрал бага байгаа мужид Релейн сарнил ($q \ll 1$), харин унтрал их байх мужид Гюйгенс-Кирхгофын дифракцийн сарнил ($q \gg 1$) ажиглагдаж байна. Унтрал өсч байгаа завсрын мужид Мигийн сарнил байна. Долгионы уртын 3-30 мм буюу давтамжийн 10-100 ГГц цараанд борооны дуслын хэмжээнй параметр q нь 0.02-7.33 хооронд байх учир радиодолгион борооны дуслаас сарних бодлогыг (4, 5) томъёогоор бодохоос өөр аргагүй юм. Энэ нийлбэр хугарлын илтгэгчтэй комплекс байх тохиолдолд удаан нийлдэг учир үүнийг бодохдоо ядаж q хүртэлх эрэмбийн гишүүдээр нийлбэр авах шаардлагатай [1,2]. Бид 20 гишүүнээр нийлбэр авсан болно.

VI. ДҮГНЭЛТ

Борооны дусал микродолгионы унтралыг үүсгэх үндсэн гурван механизм ажиглагдаж байна. Үүнд:

1. $q < 0.25$ байхад нийт унтрал зөвхөн шингээлтээс үүсэх ба долгионы уртаас бараг хамаарахгүй бага байна. Энэ мужид Мигийн коэффициентээс a_1 буюу цахилгаан диполийн цацаргалтын далайцыг илэрхийлдэг коэффициент

- хамгийн их утгатай болж унтраах чадварыг дангаараа илэрхийлдэг байна. Энэ нь Релейн сарнилийн муж юм.
2. $0.25 < q < 0.5$ байхад сарнилийн нөлөө ихсэж байгаа боловч диэлектрик резонансын шингээлт давамгайлж байна. Энэ мужид Мигийн коэффициентээс b_1 буюу соронзон диполийн цацаргалтын далайцыг илэрхийлдэг коэффициент хамгийн их утгатай болж унтраах чадварыг дангаараа илэрхийлдэг. Энэ мужид мөн диэлектрик резонанс ажиглагдана.
 3. $q > 0.5$ мужид сарнилийн унтралд оруулах хувь нэмэр ихсэж $q=1$ орчимд сарнил шингээлт хоёр тэнцэж ирээд түүнээс цааш сарнил давамгайлах болж байна. Энэ мужид унтралын огтлолд Мигийн дээд эрэмбийн коэффициентуудын оруулах хувь нэмэр ихсэх учир энэ Мигийн сарнилын муж болно.

VII. НОМ ЗҮЙ

- [1] Medeiros Filho, F., S., Cole, R., S., Sarma, A., D., “Millimetre Wave Rain Induced Attenuation: Theory and Experiments”, IEEE Proc., 1986, 133, (4) pp 308-314.
- [2] Van De Hust, H.C. “Light Scattering by Small Particles” New York, Wiley. 1957.
- [3] Kenneth V. Beard, V.N. Bringib, M. Thurai “A new understanding of raindrop shape” Atmospheric Research, Volume 97, Issue 4, September 2010, Pages 396–415
- [4] Miklós Szakall, Subir K. Mitra, Karoline Diehl, Stephan Borrmann. “Shapes and oscillations of falling raindrops - A review”, Atmospheric Research, Volume 97, Issue 4, September 2010, Pages 416–425.
- [5] Liebe, H.J, G.A. Hufford and T. Manabe. “A model for the complex permittivity of water at frequencies below 1 THz.” Int. J. IR & MM, V.12, pp659-674, 1991.

Цэгэн дефект бүхий усанболорын электрон бүтцийн судалгаа

Н.Төвжаргал^{1,*}, Ж.Даваасамбуу¹, Д.Баатархүү², Н.Цогбадрах¹

¹Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны сургуулийн
физикийн тэнхим, Улаанбаатар хот 210646, Монгол улс

²Монгол Улсын Их Сургуулийн Цөмийн физикийн судалгааны төв, Монгол улс


Янз бүрийн үнэт болон хагас үнэт чулууны өнгийг өөрчилж хүссэн өнгө хэлбэрт оруулах асуудал үргэлж судлаачид төдийгүй хэрэглэгчдийн сонирхлыг татаж байдаг. Байгалийн хагас үнэт чулуу болох усанболорыг гамма цацрагаар шарахад цацраг бодисын харилцан үйлчлэлийн дүнд түүнд олон тооны дефект үүссэнээс материалын оптик шинж чанар өөрчлөгдөж өнгөний хувиралд ордог. Энэ өнгөний өөрчлөлтийг атомын төвшинд тайлбарлах нь шинжлэх ухаан болон технологид чухал ач холбогдолтой. Иймд бид энэ ажлаар усанболор (SiO_2)-т гамма цацрагийн үйлчлэлээр үүсэж болох цэгэн дефектүүд болох нейтрал хүчилтөрөгчийн нүх, Френкелийн хос дефект зэргийг үүсгэж түүний электрон бүтэцэд хэрхэн нөлөөлөхийг *ab-initio* квант механикийн аргаар CRYSTAL14 программ ашиглан судлав.

PACS numbers: 42.70.Ce, 61.80.-x, 61.72.J-, 31.15.A-

I. Удиртгал

Байгалийн үнэт болон хагас үнэт чулуунуудыг гоёл чимэглэл, ахуйн зориулалтаар өргөн хэрэглэдэг. Зарим байгалийн хагас үнэт чулуунуудыг гамма (γ) цацрагаар шарахад тэдгээр нь өнгөний хувиралд ордог[1]. γ цацраг хатуу биетэй харилцан үйлчлэхэд тэнд цацрагийн энергиэс хамааран Комптоны сарнил, фото-цахилгаан эффект, электрон позитроны хос үүсэх гэх мэт үзэгдлүүд явагдах боломжтой. Эдгээр үзэгдлүүдийг дагалдан явагдаж байгаа олон процессуудын дүнд дээжийн өнгө хувирч байгаа болно. Энд үүсэж байгаа өнгөний хувирлын үүсэл шалтгааныг тайлбарлах нь чухал ач холбогдолтой. Ийм өнгөний хувиралд ордог хагас үнэт чулуу болох болор нь байгаль дээр усан болор, утаат болор, сүүн болор гэж нэрлэгдэх хэлбэрүүдээр элбэг тохиолддог. Усанболор (SiO_2) –ын үндсэн бүтэц нь SiO_4 тэтреадрийн юм [2]. Тэтреадрийн дөрвөн гурвалжин талаас тогтох олон талт бөгөөд тэдгээр нь гурав гурваараа оройгоороо холбогдоно. Энд дөрвөн хүчилтөрөгчийн атом нь нэг нэгээрээ тэтреадрийн оройнууд дээр байрлах бөгөөд нэг цахиурын атом тэтреадрийн төвд байрлана. SiO_4 тэтреадрийн бүтцийг зураг.1-д үзүүлэв.

Цахиурын атомын электрон бүтэц нь sp^4 орбитал дээр байрлах валентын 4 электронтой бөгөөд 3p орбитал холбоост орсон атомуудаас дөрвөн электроныг хуваалцаж аваад гадаад бүрхүүл нь бүрэн дүүрэх боломжтой болно. Хэрэв нэг цахиурын атомын эргэн тойронд дөрвөн хүчилтөрөгчийн атом байрлаж байвал хүчилтөрөгчийн атом бүр гадаад бүрхүүлийн нэг электроноо цахиурын атомд алдаад хүчилтөрөгчийн гадаад бүрхүүл бүрэн дүүрч



Зураг 1: Цэвэр усанболорын (SiO_2)-ийн гурван хэмжээст бүтэц. Бүтэц нь дараах параметруудээр тодорхойлогдоно. Үүнд Si-O холбоосны урт (d), тэтреадрийн өнцөг (ψ), тэтреадруудын дотоод холбоосны өнцөг (α), холбоосны мурийлтын өнцөг (δ_1, δ_2)[3].

тогтвортой бүтэц үүсэх боломжтой. Үүний үр дүнд $\text{Si}^{+4}\text{O}_2^{-2}$ силикатын кристалл бүтэц бүрэлддэг. Хүчилтөрөгчийн хувьд гадаад бүрхүүлд үлдсэн нэг электрон нь өөр цахиурын атомуудтай холбогдон бусад тэтреадруудыг үүсгэнэ. Тэтреадрууд нь хоорондоо хүчилтөрөгчийн атомуудаар холбогдоно. Хэрэв тэтреадрууд хоорондоо холбогдоогүй тус тусдаа оршин байвал энэ төрлийн материалыг незосилкатын гэдэг. Хэрэв хоёр тэтреадрийн хоорондоо шууд холбогдсон байвал сорасилкатын материал гэнэ. Хэрэв бүх тэтреадрууд буцаад бие биетэйгээ битүү цагираг үүсгэн холбогдсон байвал циклосилкатын материал болно. SiO_2 –ийн холбоос бол комплекс шинж чанартай. Si-O холбоосийн энерги (4.5эВ) Si-Si холбоосийн энерги (2.3эВ) –тэй харьцуулахад маш их ба иймээс Si-O холбоос нь 50:50 хувийн ионы ба ковалент хосолсон шинжтэй[4]. Ихэнх тохиолдолд SiO_4 тэтреадрийн бол маш хатуу бат бөх бүтэц байдаг.

Усанболорыг γ -цацрагаар шарахад түүний өнгө

*Electronic address: tuvjargal@num.edu.mn


өөрчлөгдөн утаат болор болдог нь цацраг бодисын харилцан үйлчлэлийн дүнд кристаллд олон янзын урвал процессууд явагдсаны дүнд үүсэх эффектүүдтэй холбоотой. Эдгээр эффектүүдийн нэг нь цэгэн дефект юм [5]. Цэгэн дефектүүд нь үүсгэж байгаа шалтгаанаасаа хамаараад олон янз байх боломжтой. Цэгэн дефектүүд нь эгэл торд атомын шилжилт үүсэх, атомуудын холбоос тасрах болон гаднын өөр хольцын атомууд орж ирснээс шалтгаалан атомын бүтцэд гажилт үүсгэдэг [6]. Цэгэн дефектүүдийг тэдгээрийн электроны конфигурацид нь үндэслэн хослоогүй электронуудаас тогтож байвал *парасоронзон* дефект, бусад тохиолдлуудыг нь *диасоронзон* дефект гэж ангилдаг.

II. Усан болорын хувийн дефектүүд

Усанболорт үүсэж байгаа дефектүүд нь түүний бүтэц, цахилгаан болон оптик шинж чанаруудад илэрхий өөрчлөлтүүдийг үзүүлдэг. Үйлдвэрлэлийн процесс, цацрагийн үйлчлэл, механик хүчлэг, температур болон даралтын өөрчлөлт, хольц зэргээс шалтгаалан маш олон янзын дефект үүсэх боломжтой. Гэвч нийтлэг тохиолдолд дефект нь цэгэн, шугаман болон хавтгай дефект байдаг[7]. Цэгэн дефектүүдийг хувийн (intrinsic) болон гадны (extrinsic) гэж ангилдаг. Хувийн цэгэн дефект нь зөвхөн өөрийн үндсэн атомуудын оролцоотойгоор үүсдэг өөрөөр хэлбэл нүх үүсэх (үндсэн атом сугарч нүх үүсэх, Schotky defect эсвэл Frenkel хос үүсэх) болон өөрийн завсар суух (өөрийн нэмэлт атом завсрын байрлалд суух) зэрэг болно. Гадны цэгэн дефект нь тухайн кристаллын үндсэн атомуудаас өөр атом гаднаас хольц хэлбэрээр суухад үүсэх болно. Цэвэр усанболорын хувьд хүчилтөрөгч болон цахиурын нүх үүсэх, тэдгээрийн атомууд өөрийн завсар суух болон Si-Si ба O-O холбоос тасрах зэрэг дефект үүсэх боломжтой. Si-O холбоосийн энерги их (4.5eV) тул химийн өгөршил болон зэврэлтэд тэсвэртэй байдаг[8]. Түүнчлэн хатуу (Mohs' hardness 7), хэврэг болон маш өндөр хайлах температуртай (1710°C) байдаг[9]. Энергийн хориотой бүсийн өргөн 9eV орчин байдаг тул оптик шинж чанарын хувьд тунгалаг, цахилгаан дамжуулалт муу байдаг[10]. Ерөнхийдөө, Si-Si ба O-O холбоо нь цахилгаан саармаг боловч холбоос тасрах үед эерэг цэнэг баригч нүхнүүд үүсэх болно. Эдгээр харьцангуй чөлөөтэй цэнэгүүд нь диасоронзон болон парасоронзон дефектүүдийг үүсгэнэ. Бүх тогтвортой парасоронзон дефектүүд нь оптик шингээлтийн бүсэд нөлөөлөх учраас тэдгээр хагас дүүрсэн энергитэй төлөвүүд валентын бүсийг шилжүүлэх болон электроныг дамжуулалтын бүсэд шилжүүлэх зэрэг аль аль нь боломжтой.

Цэгэн дефектүүд


Хувийн цэгэн дефектүүд нь үүсгэж байгаа шалтгаанаасаа хамаараад олон янз байх боломжтой. Цэгэн дефектүүдийн жишээ гэвэл: нүх үүсэх (торын зангилаа цэгт атом алга болох), завсрын (торын зангилаа биш завсарт атом байрлах) болон валентын ($Si - O$ холбоос эвдрэх) дефектүүд болно. Усанболорт үүсэх цэгэн дефектүүд нь дараах хэлбэрүүдтэй байна. Үүнд: нейтрал хүчилтөрөгчийн нүх [11]: $O \equiv Si - Si \equiv O$, перокси гүүрэн: $O \equiv Si - O - O - Si \equiv O$, гүүрэн биш хүчилтөрөгчит: $O \equiv Si - O^\bullet$, гурван координаттай цахиуран: $O \equiv Si^\bullet$ (ихэвчлэн E' төв гэж нэрлэдэг), хоёрлосон координаттай цахиуран: $O = Si^{\bullet\bullet}$. Эдгээр дефектүүд нь электрон эсвэл нүхийг барих зарим энергийн төлөвүүдийг үүсгэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Энд $\bullet$ -ээр холбоос нь эвдэрсэн хослоогүй электроныг дүрслэв. Цэгэн дефектийн үндсэн болон өдөөгдсөн электроны төлөвүүд нь усанболорын хаалттай бүсийн энергиэс бага энергийн завсартай байна. Иймээс $O \equiv Si - O^\bullet$ болон $O \equiv Si^\bullet$ дефектүүдийг валентын болон дамжуулалтын бүсийн хооронд байрлах төлөвүүдтэй холбоотой үүсдэг тул эвдэрсэн холбоосон төлөв гэж нэрлэдэг. Цахилгаан соронзон долгионы үйлчлэлээр үүсэж байгаа электроны төлөвийн шилжилттэй холбоотой дефектүүд тухайн материалын шингээлтийн болон цацаргалтын бүсийн энергийн завсарыг өөрчлөгдөх бөгөөд энэ нь тухайн материалын тунгалаг чанар өөрчлөгдөх шалтгаан болдог. Энд SiO_2 -ийн парасоронзон дефектийн нэг болох E' -төвийг электроны парасоронзон резонансын (ЭПР) спектрометр ашиглан тэртээ 50 гаран жилийн өмнө хэмжсэн байдаг[12]. ЭПР спектрээр хэт нарийн бүтцийн судалгаанаас E' -төв гэдэг нь голд нь цахиурын атом байрласан тэтраэдрийн оройнууд дээр суусан хүчилтөрөгчийн атомуудын гурав нь Si -тэй холбоотой нэг нь тасарсан хослоогүй электроноос бүрдэг болохыг мэдэх билээ [13]. E' -төв дефектийн ерөнхий хэлбэрийг зураг.2-т үзүүлэв. Энэ дефектийг $\equiv Si^\bullet$ гэж тэмдэглэдэг бөгөөд энд параллель шугамууд нь цахиуртай холбогдсон хүчилтөрөгчийн 3 холбоосыг илэрхийлж байгаа бол цэг нь хослоогүй электроныг илэрхийлнэ. ЭПР судалгаанаас



Зураг 2: E' -төв дефектийн загвар .

үзэхэд цацрагийн үйлчлэлд орсон SiO_2 -ийн хувьд E' -төвийн хэд хэдэн ялгаатай хэлбэрүүд үүсдэг[14]. Эдгээр E' -төвүүд нь цацрагийн үйлчлэлийн горим, дулааны боловсруулалт, тухайн материал дэх усны агууламж зэргээс хамаараад өөр өөр байна. Үндсэндээ дөрвөн төрлийн E' -төв байдаг тогтоосон бөгөөд

тэдгээрийг E'_α , E'_β , E'_γ , E'_s гэж тэмдэглэдэг[15]. E'_α хэлбэрийн дефект нь гамма цацрагийн үйлчлэлээр явагдах радиолитик процессийн дүнд $\equiv \text{Si}-\text{O}-\text{Si} \equiv$ холбоос дэх хүчилтөрөгчийн атом өдөөгдөөд тодорхой энергитэй болсноор химийн холбоос тасарсны дүнд үүснэ[16]. Зураг.3-т E'_α дефект үүсэх процессыг үзүүлэв.



Зураг 3: Цэвэр SiO_2 -т E'_α төв үүсэх схем. Сумтай шулуунаар хослоогүй электроны спин ба тасархай шугамаар түүний орбиталийг үзүүлэв.

Зураг.3 –д үзүүлсэн хүчилтөрөгч-хүчилтөрөгч ($\text{peroxy} \equiv \text{Si}-\text{O}-\text{O}$) холбоос харьцангуй тогтвортой төлөв болохыг онолын судалгаагаар үзүүлсэн байдаг[17][18]. Энд $\bullet\text{O}-\text{Si} \equiv$ гэж тэмдэглэгдсэн нь гүүрэн биш хүчилтөрөгчийн нүхэн төв (NBOHC) бөгөөд ЭПР судалгаанаас үзэхэд энэ төрлийн дефект цацрагийн үйлчлэлээр мөн үүсэх боломжтой. Иймээс бид гамма цацрагийн үйлчлэлээр усанболорт үүсэх зарим хувийн цэгэн дефектүүдийг үүсгэж түүний электрон бүтэц, хориотой бүсийн өргөнд хэрхэн нөлөөлөхийг *ab-initio* квант механикийн аргаар CRYSTAL14 програм[19] ашиглан судлах зорилготой.

III. Тооцооны програм болон арга

CRYSTAL код нь электроны долгионы функц, үндсэн төлөвийн энерги, энергийн градиент болон шинж чанарын *ab-initio* квант механикийн тооцооллыг гүйцэтгэдэг бөгөөд Хартре-Фок эсвэл Кохн-Шамийн гамельтониануудыг хэрэглэдэг. Уг программ нь кристаллын бүх симметрийн хувьд квант механикийн тооцоог хийж хувийн утга болон хувийн функцийг олсоноор дараах физик шинж чанаруудыг онолоор тооцоолох боломжийг олгодог. Үүнд материалын электрон бүтэц, дефект, соронзон болон диэлектрик шинж чанар, хэлбэлзэлийн давтамж, фононы дисперс, харимхай, пьезоцахилгаан болон фотоцахилгаан шинж чанар гэх мэт олон шинж чанаруудыг

тооцоолох боломжтой. Ингэхийн тулд тухайн судлах системийн геометр болон симметрийн өгөгдөлүүд мөн түүнд орж байгаа атомуудын базис олонлогууд, тоон тооцооны нарийвчлал зэргийг агуулсан оролтын файлыг бэлдэж өгөх шаардлагатай.

Хатуу биеийн физикийн судалгаанд ихэвчлэн хоёр өөр төрлийн *ab-initio* үелэх гамильтонианы фракцуудыг хэрэглэдэг. Энэ нь Хартре-Фок болон Нягтын функцийн аргууд юм. Нягтын функцийн аргад электрон электроны харилцан үйлчлэлийн хэсэгт корреляцын болон солилцолын энергийг ойролцоолох аргаар тооцож боддог бол Хартре-Фокийн аргад электроны солилцолын энергийг тооцдог боловч корреляцын хэсгийг үл тооцдог. Бид энэ ажлыг нягтын функцийн арга (DFT) ашиглан тооцоолсон бол атомын орбиталаар GTO (Gaussian type functions) авсан ба энэ нь бодит хатуу биеийн сфер гармоникийг Гауссын функцээр үржүүлсэн функц юм. Түүнчлэн гамильтонианаар B3LYP (Becke -ийн гурван-параметрт солилцолын функц[20] болон шугаман биш Lee-Yang-Parr корреляцын функц[21]) -ийг хэрэглэсэн. Тооцооны нарийвчлалыг сайжруулахын тулд $2x2x2$ хэмжээст супер тор дээр тооцоог гүйцэтгэв.


IV. Тооцооны үр дүн

Металл биш материалууд нь түүний электрон бүтцээс хамааран үзэгдэх гэрлийн

мужид ихэвчлэн тунгалаг байдаг. Түүнчлэн, гэрлийн ойлт, шингээлт, хугарал болон нэвтрэлтийг авч үзэх хэрэгтэй. Электроны зоны бүтэц болон төлөвийн нягт нь материалын оптик шинж чанарыг тодорхойлох үндсэн ойлголтууд юм[22].

Материалын электрон бүтцийг судалснаар түүний хаалттай бүсийн өргөн, электрон бүтцэд атомуудын үзүүлж байгаа нөлөө зэргийг тодорхойлох боломжтой. Материалын гэрлийн цацрагийн шингээлтэд электроны туйлшрал болон валентын болон дамжуулалтын бүсийн

хооронд электрон шилжих гэсэн үндсэн хоёр механизм нөлөөлдөг. Үндсэндээ материалын электрон бүтцээс хамаарна. Дүүргэгдсэн валентын бүс дэх электронууд гэрлийн фотоны өдөөлтөөр хориотой бүсийг давж хоосон дамжуулалтын бүсэд шилжихдээ гэрэл шингээдэг бөгөөд энэ процессын загварыг зураг.4 -д үзүүлэв. Үүний дүнд дамжуулалтын бүсэд чөлөөт электрон, валентын бүсэд нүх үүсдэг. Өдөөлтийн энерги ΔE нь шингээсэн фотоны давтамжтай $\Delta E = h\nu$ гэсэн хамааралтай.



Зураг 4: (a) Металл биш материалын фотоны шингээлтийн механизм. Энд өдөөгдсөн электрон хориотой бүсийг давахад валентын бүсэд нүх үүснэ. Шингээсэн фотоны энерги ΔE нь хориотой бүсийн энерги E_g -ээс их байх шаардлагатай. (b) Өдөөгдсөн төлөвөөс хориотой бүсийг давж шилжсэн электрон гэрлийн фотон цацаргана.

Электроныг өдөөж байгаа фотоны энерги нь хориотой бүсийн энерги E_g -ээс их байх хэрэгтэй.

$$h\nu > E_g, \quad (1)$$

буюу долгионы уртаар илэрхийлбэл,

$$\frac{hc}{\lambda} > E_g. \quad (2)$$

Үзэгдэх гэрлийн хамгийн бага долгионы урт $\lambda(min)$ нь $0.4\mu\text{м}$, гэрлийн хурд $c = 3 \cdot 10^8 \text{м/с}$, Планкийн тогтмол $h = 4.13 \cdot 10^{-15} \text{эВ}\cdot\text{с}$ болохыг тооцон үзэгдэх гэрлийг шингээж болох хамгийн их хориотой бүс $E_g(max)$ -ийг тооцох боломжтой.

$$E_g(max) = \frac{hc}{\lambda(min)} = 3.1\text{эВ} \quad (3)$$

Өөрөөр хэлбэл, металл биш материалын хориотой бүсийн энерги 3.1эВ -аас их бол үзэгдэх гэрэл шингээхгүй гэсэн үг бөгөөд хэрэв ийм материал өндөр цэвэршилтэй байвал өнгөгүй тунгалаг байна. Мөн үзэгдэх гэрлийн хамгийн их долгионы урт $\lambda(max)$ нь $0.7\mu\text{м}$ болохыг тооцон үзэгдэх гэрлийг шингээж болох хамгийн бага хориотой бүс $E_g(min)$ -ийг тооцвол,

$$E_g(min) = \frac{hc}{\lambda(max)} = 1.8\text{эВ}. \quad (4)$$

Эндээс үзэхэд, хориотой бүсийн энерги нь 1.8эВ -аас бага байх хагасдамжуулагч материалуудын хувьд валентын бүсээс дамжуулалтын бүсэд электрон шилжихдээ бүх үзэгдэх гэрлийг шингээх бөгөөд эдгээр материалууд нь тунгалаг биш байдаг. Хориотой бүсийн энерги нь 1.8эВ

-аас 3,1эВ -ийн хооронд байх материалуудын хувьд үзэгдэх гэрлийн тодорхой спектрийн мужид гэрлийг шингээх бөгөөд янз бүрийн өнгөтэй байх боломжтой.

Бид энэ ажлаар цэвэр усанболор болон гамма цацрагийн үйлчлэлээр усанболорт үүсэх боломжтой нейтрал хүчилтөрөгчийн нүх (V_O^x), Френкелийн хос дефект зэрэг хувийн цэгэн эффектүүдийг үүсгэж түүний электрон бүтэц, өнгөний өөрчлөлтөд хэрхэн нөлөөлөхийг судалсан.

Ферми төвшний ойролцоох төлөвийн нягт нь материалын физик шинж чанарыг үзүүлэх чухал хэсэг юм. Эндээс хориотой бүсийн энергийг тодорхойлох, цэгэн эффектүүдийн нөлөөгөөр электрон бүтэц хэрхэн өөрчлөгдөж байгааг харуулах боломж олгодог. CRYSTAL кодын хувьд нийт төлөвийн нягт $\rho_{tot}(\epsilon)$ нь атомын $\rho_A(\epsilon)$ болон орбиталийн $\rho_\mu(\epsilon)$ -ийн нягтаар дараах


байдалтай илэрхийлэгддэг.

$$\rho_\mu = 2/V_{BZ} \sum_j \sum_\nu \sum_{\underline{g}} \int_{BZ} d\underline{k} S_{\mu\nu}(\underline{k}) a_{\mu j}(\underline{k}) a_{\nu j}(\underline{k}) e^{i\underline{k}\underline{g}} \delta[\epsilon - \epsilon_j(\underline{k})]$$

$$\rho_A(\epsilon) = \sum_{\mu \in A} \rho_\mu(\epsilon)$$

$$\rho_{tot}(\epsilon) = \sum_A \rho_A(\epsilon) \quad (5)$$

Системийн төлөвийн нягт (DOS) нь электрон суух боломжтой төвшин бүрийн энергийн интервал дэх төлөвийн тоог илэрхийлдэг.



Зураг 5: Усанболор (SiO_2)-ын төлөвийн нягтын зураг. Энд: (a) Цэвэр усанболор, (b) Нейтрал хүчилтөрөгчийн нүхэн дефекттэй усанболор, (c) Френкелийн хос дефекттэй усанболор, E_g хориотой бүсийн энерги, E_a акцептор төлөвийн энерги, E_d донор төлөвийн энерги.

Системийн төлөвийн нягтын зургийг
байгуулснаар хориотой бүсийн өргөнийг

тооцоолох болон электрон бүтцийг харах

боломжтой. Бид энд цэвэр усанболор, Френкелийн дефект болон хүчилтөрөгчийн нейтрал нүх бүхий усанболорын төлөвийн нягтыг тооцоолсон үр дүнг зураг.5 -т үзүүлэв. Эндээс бид гамма цацрагийн үйлчлэлээр усанболорт үүсэх зарим хувийн цэгэн дефектийн нөлөөгөөр түүний электрон бүтэц, хориотой бүсийн өргөн хэрхэн өөрчлөгдөхийг харах боломжтой. Зураг.5(a)-аас цэвэр усанболорын хориотой бүсийн өргөнийг 8.7эВ болохыг үзүүлэв, энэ нь бусад судалгааны үр дүнтэй сайн тохирч байна. Иймээс цэвэр кристалл усанболор нь тусгаарлагч шинж чанартай, тунгалаг өнгөтэй байдаг.

Зураг.5(b)-д нейтрал хүчилтөрөгчийн нүхэн(V_O^x) дефект бүхий усанболорын төлөвийн нягтыг үзүүлэв. SiO_4 тетраэдрин хувьд төвд нь Si^{+4} катион болон оройнууд дээр нь O^{-2} анион суусан байдаг. Эндээс нэг O -ийн атом сугараад анионы нейтрал нүх үүсэхэд катион Si^{+3} болно. Энд цахиурын 3s төлөв дээрх нэг электрон суларч үлдэх бөгөөд дамжуулалтын бүсийн орчим донор төлөв үүсгэн сууна. Цахиурын 3s төлөвт нэг электроны дутагдалтай болж валентын бүсийн орчим акцептор төлөв үүсэх болно. Түүнчлэн энд акцептор төлөвийн энерги $E_a = 1.36эВ$, донор төлөвийн энерги $E_d = 1.63эВ$ байна. Энд гэрлийн үйлчлэлээр валентын бүсээс акцептор төлөв рүү, донор төлөвөөс дамжуулалтын төлөв рүү электрон шилжиж гэрлийг шингээнэ. Мөн энэ эффектийн нөлөөгөөр усанболорын хориотой энергийн бүсийн өргөн 3.2эВ болж нарийсаж байна.

Зураг.5(c)-д Френкелийн хос дефект бүхий усанболорын төлөвийн нягтыг үзүүлэв. Френкелийн дефект нь нейтрал хүчилтөрөгчийн нүх болон цацрагийн үйлчлэлээр сугарсан холбоост ороогүй завсар суусан хүчилтөрөгчийн атомаас тогтоно. Энд нейтрал хүчилтөрөгчийн нүх үүсэх болон электрон бүтцэт орох өөрчлөлт нь зураг.5(b)-тэй адил байна. Харин холбоост ороогүй завсар суусан хүчилтөрөгчийн атомын хувьд 2p орбиталь нэмээд 2 электрон суух боломжтой тул валентын бүсийн орой орчим акцептор төлөв үүснэ. Френкелийн хос үүсэх дефектийн нөлөөгөөр усанболорын хориотой энергийн бүсийн өргөн 2.4эВ болж нарийсан

хагасдамжуулагч шинж чанартай болж өөрчлөгдөж байна. Түүнчлэн энд акцептор төлөвийн энерги $E_a = 1.36эВ$, донор төлөвийн энерги $E_d = 2.17эВ$ байна. Энд гэрлийн үйлчлэлээр валентын бүсээс акцептор төлөв рүү, донор төлөвөөс дамжуулалтын төлөв рүү электрон шилжиж гэрлийг шингээнэ. Эдгээр дефектийн тохиолдолуудад үзэгдэх гэрлийн мужид гэрлийг бүрэн шингээх нөхцөл бүрдэж байгаа тул тунгалаг биш хар өнгөтэй болж харагдаж байгаа болно.

V. Дүгнэлт

Байгалийн хагас үнэт чулуу болох усанболорыг гамма цацрагаар шарсны үр дүнд түүнд олон тооны дефект үүссэнээс материалын өнгө өөрчлөгддөг. Иймд бид энэ ажлаар усанболор (SiO_2)-т гамма цацрагийн үйлчлэлээр үүсэж болох хувийн цэгэн эффектүүд болох нейтрал хүчилтөрөгчийн нүх, Френкелийн хос дефект зэргийг үүсгэж түүний электрон бүтэц, хориотой бүсийн өргөн зэрэг хэрхэн нөлөөлөхийг судлав. Тооцооны үр дүнгээс үзэхэд бидний авч үзсэн цэгэн эффектүүдийн нөлөөгөөр хориотой бүсийн завсарт донор болон акцептор төвшин үүссэнээр усанболорын электрон бүтэц өөрчлөгдөж, хориотой энергийн бүсийн өргөн нарийсан хагасдамжуулагч шинж чанартай болж өөрчлөгдөж байгааг үзүүлэв. Мөн цэгэн дефектийн үүсгэж байгаа донор болон акцептор төлөвийн энергийн төвшиний нөлөөгөөр гэрлийг шингээж тунгалаг биш өнгөтэй болж байна. Цаашид гамма цацрагийн үйлчлэлээр үүсэж болох хувийн болон гаднын цэгэн эффектүүд усанболорын оптик шинж чанарт хэрхэн нөлөөлөхийг нарийвчлан судлах болно.

Талархал

Энэхүү ажлыг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж суурь судалгааны SST_018/2015 төслийг санхүүжүүлсэн ШУТС болон БСШУС яаманд талархал илэрхийлье.

- [1] Baatarkhuu.D, Tuvjargal.N, Ochirkhuyag.T, Davaasambuu.J, Shilagardi.G., "The optical absorption and EPR study of Gamma irradiated and heat-treated natural quartz" Mong.J. Phys., Issue 2,(2016), 436.
- [2] Mozzi R. L. and Warren B. E., "The Structure of Vitreous Silica" J. Appl. Crystallogr. 2 (1969) 164.
- [3] Henderson G. S. and Baker D. R. (eds.), "Synchrotron Radiation: Earth, Environmental and Material Sciences Applications," Short Course Series

30, Mineralogical Association of Canada. (2002)159-178.

- [4] Edwards A. H., Fowler W. B. and Robertson J., "Structure and imperfections in amorphous and crystalline silicon dioxide" R. Devine A. B., Duraud J.-P. and Dooryhée E. (eds.), John Wiley and Sons Ltd., (2000), p.253
- [5] Ed. Catlow R., "Defects and disorder in crystalline and amorphous solids" Kluwer Academic Publishers (1994)

- [6] Kittel C., "Introduction to Solid State Physics" John Wiley and Sons (1971).
- [7] Stevens-Kalceff M. A. and Philips M. R., "Cathodoluminescence microcharacterization of the defect structure of quartz" Phys. Rev. B 52 (1995) 3122.
- [8] Lamkin M. , Riley F. and Fordham R., "Oxygen Mobility in Silicon Dioxide and Silicate Glasses" A Review, J. Eur. Ceram. Soc. 10 (1992) 347.
- [9] Lide D. R., CRC Handbook of Chemistry and Physics, 85th edition, CRC Press, (2004).
- [10] Fan X. D. , Peng J. L. and Bursill L. A., "Joint Density of States of Wide-Band-Gap Materials by Electron Energy Loss Spectroscopy" J. Non-Cryst. Solids 24 (1977) 155.
- [11] Elliott S.R., "Physics of amorphous materials" Longman, London, 2 Ed. (1990).
- [12] Weeks R. A., "Paramagnetic Resonance of Lattice Defects in Irradiated Quartz" J. Appl. Phys. 27 (1956) 1376.
- [13] Н.Төвжаргал, Д.Баатархүү, Т.Очирхуяг, Ж.Даваасамбуу, Г.Шилагарди., "Гамма цацрагийн үйлчлэлээр Усанболорт үүсэх парасоронзон дефектийн судалгаа" МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг 449, ФИЗИК СЭТГҮҮЛ (22) x11, 2016
- [14] Griscom D. L., "Glass Science and Technology" Academic, London, Vol. 4B (1990a) 151.
- [15] Skuja L., "Optically active oxygen-deficiency-related centers in amorphous silicon dioxide" J. NonCryst. Solids 239 (1998) 16.
- [16] Uchino T. , Takahashi M. and Yoko T., "Structure and Generation Mechanism of the PeroxyRadical Defect in Amorphous Silica," Phys. Rev. Lett. 86 (2001) 4560.
- [17] Griscom D. L., "E' center in glassy SiO₂: Microwave saturation properties and confirmation of the primary ²⁹Si hyperfine structure" Phys. Rev. B 20 (1979a) 1823
- [18] Griscom D. L., "The electronic structure of SiO₂: A review of recent spectroscopic and theoretical advances" Modern Phys. Lett. B 12 (1998) 541.
- [19] R. Dovesi, V.R. Saunders, C. Roetti, R. Orlando, C. M. Zicovich-Wilson, F. Pascale, B. Civalleri, K. Doll, N.M. Harrison, I.J. Bush, Ph. D'Arco, M. Llunell, M. Causa and Y. Noel, CRYSTAL14 User's Manual, University of Torino, Torino, (2014)
- [20] A. D. Becke ., J. Chem. Phys. 98, 5648 (1993).
- [21] C. Lee, W. Yang, and R. G. Parr ., Phys. Rev. B 37, 785 (1988).
- [22] William D. Callister, David G. Rethwisch., "Materials Science and Engineering: An Introduction" John Wiley and Sons, Inc., (2014).

Утааны механик шинж чанарыг судлах хялбар арга

Ж.Ванчинхүү*, Ж.Даваасамбуу, Б.Бат-Эрдэнэ

МУИС, ШУС, Физикийн тэнхим

Утааны бөөмцөрийн шугаман хэмжээ, тоон нягт буюу концентраци, хурд, бөөмцөр хоорондын зай, утаан дахь бөөмцөрийн концентраци зэрэг зарим механик шинж чанарыг хялбар тодорхойлох боломжит арга, аргачлалыг энд судлав. Энд дэвшүүлж байгаа аргыг ашиглан тамхины утааны зарим механик шинж чанарыг тогтоож агаар мандал руу орж байгаа эмиссийг үнэлэв. Агаарын бохирдлын судалгааны ажилд тохиромжтой байх зарим шинэ параметруудийг дэвшүүлэн гаргасан.

PACS# 64.70.ps, 68.60.Bs

Удиртгал

Төрөл бүрийн түлшний шаталтаас ялгаран гарах утаа нь шаталтын зайлшгүй үр дагавруудын нэг юм. Шаталт нь физик химийн олон шаттай процессуудын явцад түлшний материалууд хүчилтөрөгчтэй урвалд орох процесс юм [1-3]. Энэ процессын явцад ялгарах энерги нь дулаан ба цацаргалт хэлбэрээр харин урвалын бүтээгдэхүүнүүд нь утаа хэлбэрээр гадагшиж байдаг. Харин түлшинд агуулагдах үл шатах хэсгүүд нь үнс болж үлддэг. Шаталтаас ялгарч байгаа утаа нь түлшний халалт болон шаталтаас гарах хийн бүтээгдэхүүнүүд, шаталтын явцад бий болсон хатуу болон шингэн төлөвт орших жижиг хэсгүүдийг агуулж байдаг [2]. Эдгээр жижиг хэсгүүдийг нийтэд нь утааны бөөмцөр (smoke particulate) гэж нэрлэдэг. Эдгээр нь галаас гарахдаа харьцангуй өндөр температуртай байдаг бөгөөд утаатай хамт гадагшлах явцад саадын гадаргуу дээр конденсацлаж тэндээ сууж үлддэг. Үүнийг бид хөө, ис нэршлээр нь мэднэ.

Утааны бөөмцөрүүд гэрэл сарниулдаг учраас утаа бидний нүдэнд тод харагдах төдийгүй гэрэл шингээдэг учраас агаар мандал дотор их хэмжээгээр хуримтлагдсан үедээ үзэгдэх орчны хэмжээг хязгаарлаж байдаг. Үүнээс гадна эдгээр нь агаар мандлыг бохирдуулагч гол агент юм. Эдгээрийн концентраци, тус бүрийн хэмжээ, хоорондын зай, суултын хурд нь утааны механик шинж чанарыг үзүүлдэг гол хэмжигдэхүүнүүд юм.

Утааны бөөмцөрийн физик шинж чанар, бүтцийг рентген дифракц, Раман спектроскоп, Scanning Electron Microscopy with Energy Dispersive X-Ray (SEM-EDX) зэрэг аргуудаар олон талаас нь судалсан байдаг [4-7]. Харин янз бүрийн түлшнээс гарч байгаа утааны механик шинж чанар тухайлбал бөөмцөрийн концентраци, бөөмцөрийн шугаман хэмжээ,

тоон нягт, бөөмцөрийн материалын нягт зэргийг центрфугтэй масс анализатор, Differential Mobility Spectrometer (DMS) багажаар судалсан байдаг [8-10] бөгөөд утааны бөөмцөрийн оптик шинж чанарыг ч мөн авч үзсэн байдаг [11-12]. Агаарын бохирдолд утааны механик шинж чанар нөлөөллийн хувьд чухал ач холбогдолтой байдаг. Утааны механик шинж чанарыг мэдсэнээр утаанаас үүдэлтэйгээр агаарт бий болсон бохирдуулагч агентуудын хэмжээ, нөлөөг тогтоох боломж бүрддэг.

Манай улсын төв суурин газруудын агаарын бохирдол ихэссэнтэй холбоотойгоор энэ чиглэлийн судалгааны ажил 2000-иад оны сүүлчээс хийгдэж эхэлсэн. Агаарын бохирдлын мониторинг хийх, шаталтаас гарч байгаа агаар бохирдуулагч агентуудыг судлахдаа хий хэлбэртэй бохирдуулагчдыг хийн анализатор ашиглан хэмждэг. Харин бөөмцөрийг судлахдаа шүүх аргыг өргөн ашиглаж байна. Шүүх аргаар агаар бохирдуулагч агентуудын хэмжээг тогтохдоо утаа, эсвэл бохирдолтой агаарыг соруулан авч механик шүүлтүүр ашиглан түүний доторхи бөөмцөрүүдийг шүүж аваад түүнийхээ массыг хэмжиж энэ массыг соруулсан утааны эзлэхүүнд харьцуулан бохирдлын хэмжээг мкг/м^3 нэгжээр илэрхийлэн гаргадаг. Энэ зарчим дээр тулгуурлан ажилладаг тусгайлсан багажууд ч бас бий. Гэхдээ ийм багажуудын хэмжих хязгаар хязгаарлагдмал байдаг. Тухайлбал, бохирдуулагч агентын концентрацийг тодорхойлдог DustTrak төрлийн багажуудын хэмжих хязгаар 600 мкг/м^3 -аас хэтэрдэггүй. Гэтэл галаас гарч байгаа утааны концентраци хэдэн г/м^3 хүрэх тохиолдол ч бий. Энэ тохиолдолд утааны бөөмцөрийн концентраци багажийн хэмжих хязгаарыг давж гарах учраас шууд хэмжих боломжгүй болж механик шүүлтүүр ашиглан ялгаж аваад дараа нь хэмжих арга руугаа шилжих шаардлагатай болдог. Ингэж хэмжихэд олон тооны багаж

* Electronic address: j.vanchinkhuu@num.edu.mn

нэмэлт материал шаардлагатай болох төдийгүй хэмжилт боловсруулалтанд ихээхэн хугацаа шаардагддаг.

Бөөмцөрийн хэмжээг тодорхойлох орчин үеийн нарийн аргууд байдаг боловч үнэ ихтэй багаж шаарддаг, нөгөө талаас манай нөхцөлд олдоц муу байна.

Нэгж үүсгэгчээс гарч агаар мандал руу орж байгаа бохирдуулагч агент бүрийг тогтоож түүний гарцыг хянаж агаар мандал руу орох хувь хэмжээг тогтоогдсон хэмжээнд байлгах нь агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны нэг чухал зорилт юм. Шаталтаас гарч байгаа бохирдуулагч агент бүрийн гарцыг тодорхойлох нь олон төрлийн багажуудыг нэгэн зэрэг ашиглан хийх томоохон цогц ажил байдаг. Манай улсын төв суурин газрын агаарын бохирдлын ихэнх хэсгийг утааны бөөмцөрүүд бий болгож байдаг бөгөөд агаар мандал дахь бөөмцөрийн хэмжээ ихэссэнээр утаан манан үүсэж харагдах орчныг бууруулж байдаг. Үүний зэрэгцээ агаарын доторхи тоосонцорын концентраци ихэссэнээр түүний амьсгалаар дамжин амьд биеийн дотор орох магадлал нь нэмэгдэж халдварт болон халдварт бус өвчлөлийн шалтгаан болдог. Ийм учраас агаарын бохирдлын судалгаанд утааны тоосонцорын хэмжээг тогтоох явдал эн тэргүүнд зайлшгүй авч үзэх асуудал болдог.

Бид энэ судалгааны ажилд төрөл бүрийн шаталтаас үүдэлтэйгээр агаар мандал руу орж байгаа бохирдуулагч агентуудын дотроос нөлөөллийн хувьд хамгийн өндөр хэмжээтэй байдаг утааны тоосонцорын механик шинж чанарыг хэрхэн хялбар судлах тухай асуудлыг дэвшүүлэн тавьж байгаа юм.

Аливаа түлшний шаталтын явцад тодорхой хэмжээтэй бөөмцөрүүд (эдгээрийг заримдаа шаталтын ширхэгт бүтээгдэхүүнүүд гэдэг) үүсч тодорхой хурдтайгаар галаас гадагшилж байдаг. Эдгээр нь микрометрийн эрэмбийн хэмжээтэй бөгөөд гэрэл сарниулагч объект байдаг. Бөөмцөрөөс сарниж байгаа энэ гэрэл нь тухайн бөөмцөрийн талаар болон системийн талаар их хэмжээний мэдээлэл агуулж байдаг. Манай шийдэл утааны бөөмцөрийн гэрэл сарниулдаг энэ чанарыг ашиглаж байгаа бөгөөд утаан дээр гэрэл тусган түүнээс сарнисан гэрлийг бүртгэж авах замаар гэрэл сарниулагч объект болон системийн механик шинж чанаруудыг богино хугацаанд тогтоох хялбар бөгөөд үр дүнтэй замыг санал болгодог.

Жижиг бөөмцөрүүд агуулсан утаа, уур, үүл зэрэг дисперсэт систем дээр тодорхой долгионы урттай дан өнгийн гэрэл тусгахад түүнээс

сарнисан гэрлийн эрчим I дараах томъёогоор тодорхойлогддог [2]:


$$I \cong I_0 l \Omega \eta \sum_i c_i \sigma_{i,sc}$$

I_0 -тусгаж байгаа гэрлийн эрчим, l -лазерын цацрагийн ажиглагдаж буй урт буюу систем дотуур туулсан зай (ойролцоогоор 1 мм байна), Ω -ажиглаж буй биелэг өнцөг, η –гэрэл бүртгэх детекторын ашигт ажиллагааны коэффициент, c_i -сарниулагч төвүүдийн концентраци, $\sigma_{i,sc}$ - сариулагч төвийн сарниулах огтлол.

Энэ гэрлийг бүртгэн авч гэрлийн эрчмийг хэмжсэнээр системийн дотор байгаа бөөмцөрийн концентрацийг тодорхойлж болно [2,3]. Үүнээс гадна гэрлийн эрчим хангалттай их байхад энэ сарнисан гэрлийг микроскопын объектив рүү чиглүүлэн түүний харааны хавтгайд фокуславал түүн дотор байгаа бөөмцөрүүд нүдэнд үзэгдэхүйц тодорхой харагддаг. Нэгэнт ингэж нүдээр харж байгаа бол түүний дээр дурдсан механик шинж чанаруудыг окулярын хуваарийг ашиглан хэмжиж авч болно.

Туршилтын багаж төхөөрөмж

Микроскоп Бөөмцөрийн дээр дурдсан механик шинж чанаруудыг энгийн нүдээр харж тогтооход микроскоп, объектив микрометр юмуу дифракцийн тор шаардлагатай болдог. Харин бөөмцөрийг бүртгэж авах тохиолдолд фотоэлемент юмуу CCD камер хэрэглэгдэнэ.



Зураг 1. а) Микроскопын харааны талбайд үүссэн объектив микрометрийн дүрс (хоёр зураасын хоорондох зай 10 мкм), б) 600х өсгөлттэй микроскопын хуваарь бүхий окулярын хавтгайд харагдаж байгаа 1/100 дифракцийн торын өссөн дүрс.

Объект микрометрийг дүрсийн хэмжээг тогтооход ашиглах бөгөөд ихэнх объект микрометрийн хуваарийн үнэ 10 мкм байдаг (Зураг 1а) учраас бага хэмжээтэй объектийн дүрсийг тогтооход тохиромжтой биш байдаг. Ийм учраас илүү нарийвчлал бүхий объектийг ашиглах шаардлагатай болдог. Орчин үеийн дифракцийн торын тогтмол 50-2500 зураас/мм

(Зураг 16). Энэ тохиолдолд нэг зураасын хоорондох зай 20-0.4 мкм байна.

Микроскопын өсгөлт K нь объективын өсгөлт $k_{об}$ ба окулярын өсгөлт $k_{ок}$ -ийн үржвэрээр тодорхойлогддог:

$$K = k_{об} \times k_{ок}.$$

Микроскопын объективын өсгөлт 10-100, окулярын өсгөлт голчлон 10, 15, 20, 25 байдаг. Ийм учраас оптик микроскопын максимум өсгөлт 2500 байна.

Оптик микроскопын хувьд өсгөлтөөс гадна уг микроскопоор ажиглаж болох хамгийн бага хэмжээ нь түүний бас нэг чухал үзүүлэлт болдог. Энэ нь микроскопын ялгах чадвараар тодорхойлогддог. Ялгах чадвар нь өсгөгдсөн дүрс дотор байгаа элементүүдийн ялгарлыг үзүүлдэг бөгөөд объект дээр байгаа 2 цэгийн микроскопоор харахад ялгарч харагдах хамгийн бага зайгаар тодорхойлогддог. Үүнийг Релейн шалгуурыг ашиглан тухайн микроскопын хувьд дараах томъёогоор тодорхойлж болно:

$$L = \frac{1.22\lambda}{NA_{obj} + NA_{cond}}$$

Энд: λ - ажлын гэрлийн долгионы урт бөгөөд манай судалгаанд хэрэглэсэн ногоон гэрлийн лазерын хувьд $\lambda = 0.530$ мкм, $NA_{obj} = n \sin(\theta/2)$ -микроскопын объективын тоон аператур, $NA_{cond} = n \sin(\theta'/2)$ -конденсерын тоон аператур, n - объектив ба тавиур эсвэл конденсер ба тавиурын хоорондох орчны хугарлын илтгэгч бөгөөд агаар байгаа бол $n = 1$ байна, θ, θ' - апературын өнцөг (олонхи конденсерийн апературын өнцөг нь 144° байх бөгөөд үүнд харгалзан тоон аператур нь 0.95 байдаг). Микроскопын хязгаарын ялгах чадвар нүдний хамгийн сайн харах 514 нм долгионы урттай гэрэлд харгалзах ба 0.26 мкм байдаг. Харин харж болох хамгийн бага долгионы уртын (400 нм) хувьд 0.2 мкм байхыг тогтоож болно. Бидний ашиглаж байгаа системийн хувьд конденсерын аператур тооцогдохгүй учраас ногоон лазерын хувьд 40х ба 100х өсгөлттэй объектив бүхий микроскопын ялгах чадвар харгалзан $L = \frac{1.22\lambda}{NA_{obj}} = 0.99$ мкм, 0.51 мкм байна.

Окулярын хуваарийн үнэ Объектийн хэмжээг микроскопын харааны талбайд байгаа хуваарьтай харьцуулах замаар тодорхойлдог. Микроскопын окулярын хавтгайд хуваарьтай зураас байрладаг. Эдгээр зураасын хоорондох зай буюу хуваарийн үнийг өсгөлт бүр дээр тодорхойлох шаардлагатай. Үүний тул объектомикромметр ашиглана. Тухайлбал, Зураг 1 б-д 1/100 зураас бүхий дифракцийн зургийн

өсгөсөн дүрсийг үзүүлэв. Энэ дүрсийн m ширхэг зураас окулярын хуваарийн n зураастай давхцаж байгаа учраас окулярын хуваарийн үнэ дараах томъёогоор олдоно:

$$d = m \cdot \frac{l}{n},$$

энд: l -дифракцийн торын зэргэлдээ хоёр зураасын хоорондох зай. Энэ зургийн окулярын хуваарийн үнэ 1.875 мкм байна. Энэ утгыг тодорхойлсноор бид микроскопын харааны хавтгайд фокуслагдсан дүрсийн хэмжээг окулярын хуваарийг ашиглан тогтоох боломжтой болж байгаа юм. Энэ хэмжилтийг ялгаатай тооны зураасуудын хооронд хэд хэдэн удаа хийж дундажлан хуваарийн үнийг нарийвчлан тогтооно. Дифракцийн тор эсвэл объект микрометрийн хуваарийн үнэ тодорхойгүй байгаа бол тэдгээрийг дифракцийн үзэгдэл ашиглан тодорхойлж болно гэдгийг энд дурдая.

Утааны камер Утаа нь хөдөлгөөнт объект учраас түүнийг ажиглахын тулд нэг чиглэлд тогтвортой урсгах юм уу эсвэл тодорхой орон зайн дотор «түгжих» шаардлагатай болдог. Үүнийг хэрэгжүүлэхэд утааны камерыг ашигладаг. Энэ нь тодорхой эзлэхүүнтэй, жигд хөндлөн огтлолтой нэг талаас нь ажиглаж, өөр нэг талаас нь гэрэлтүүлж болох тунгалаг цонхууд бүхий битүү сав юм (Зураг 2). Утааг камерт оруулж үзэгдэх гэрлээр гэрэлтүүлэхэд утааны бөөмцөрөөс гэрлийн сарнил үүсдэг. Утааны бөөмцөрүүдийн сарниулсан гэрлийг микроскопын харааны талбайд чиглүүлэн фокуслаж бөөмцөрийн тод дүрсийг гарган авна. Дүрсийг CCD камераар компьютерт дамжуулж болно.


Шаталтаас ялгарч байгаа утааг хоолойгоор дамжуулан ажиглалтын камер луу оруулдаг. Бага диаметртай хоолойгоор дамжуулан утааг камерт оруулах нь хялбар биш байдаг. Утааг оруулахын тулд шаталт ба камерын хооронд даралтын градиент үүсгэх шаардлагатай бөгөөд үүнийг температураар удирдаж гүйцэтгэх нь илүү зохимжтой байдаг.

Утааны бөөмцөрийн хурдыг хэмжих

Утааны камерыг микроскопын тавиурт бэхэлж лазерын гэрлийг асаасны дараа утааг камерт оруулахад утааны бөөмцөрүүд лазерын гэрлийг сарниулсаны улмаас камер дотор тархаж буй гэрлийн дагууд тод ногоон өнгөтэй цилиндр үүснэ. Микроскопын тубусыг хөдөлгөн (зарим микроскопт суурийг шилжүүлдэг) энэ цилиндрийн хөндлөн огтлолын аль нэг хөвч болон өндрийг дайрсан хавтгайг харааны талбайд фокуслаж утааны доторхи бөөмцөрийн

тод дүрсийг гарган авна. Камерт ямар нэг алдагдал (leak) байхгүй бол утааны урсгал жигдрэх үед камерын орох гарах хоолойгоор ижил хэмжээний утаа урсана. Энэ үед утааны

хурд тогтмол байх бөгөөд бөөмцөрүүд урсгалын дагуу нэг зүг чиглэн тогтмол хурдтай хөдөлнө. Утааны бөөмцөрийн чиглэсэн хөдөлгөөний хурд нь үнэндээ утааны урсгалын хурд юм.




Зураг 2. Утааны бөөмцөрийн механик шинж чанарыг тодорхойлоход ашиглах камер бүтэц, түүний гэрэлтүүлэг.

Ийм учраас утааны бөөмцөрийн хурдыг хэмжиж утааны хурдыг тодорхойлно. Бөөмцөрийн хөдөлгөөний хурдыг нүдээр ажиглаж хэмжихийн оронд түүний хөдөлгөөнийг CCD камер ашиглан бичиж аваад боловсруулалт хийх нь илүү тохиромжтой байдаг. Камерын бичлэгийн хурдаас хамаарч бүртгэгдэж байгаа бөөмцөр цэгээр эсвэл тодорхой урттай гэрэлтэй шугам хэлбэртэй бүртгэгддэг. Хэрэв CCD камерын бичих хурд бага бол хөдөлж байгаа бөөмцөр шугам байдлаар дүрслэгдэнэ (Зураг 3).

Энэ тохиолдолд бөөмцөрт харгалзан бичигдсэн шугамын урт l -ийг камерын бичлэгийн интервал τ -д хувааж олно:

$$v = \frac{l}{\tau}.$$

Шугамын уртыг окулярын хуваариас тоолж аваад хуваарийн үнээр үржүүлж олно. Энэ ажилд бид $1/8$ с бичлэгийн интервалтай CCD камер ашиглав.



Зураг 3. Бүрэн шаталтын үед ялгарах утааны хурдтай утааны бөөмцөрийн хөдөлгөөн (өсгөлт 100х, хуваарийн үнэ 8.68 мкм)

Иймд Зураг-3-г үзүүлсэн бөөмцөрийн хурд $v = \frac{100.73 \text{ мкм}}{0.125 \text{ с}} = 804 \text{ мкм/с}$ байна.

Нөгөө талаас энэ хурд үнэн эсэхийг зураасын хөдөлгөөний хурдаар магадлаж болно. Зураасын эхний дөрвөн байрлалд харгалзах хугацааны эгшин өгөгдсөн учраас энэ хурд дараах утгатай байна:

$$\bar{v} = \frac{l}{\tau} = 815 \text{ мкм/с}.$$

(энд бөөмцөр t хугацааны дотор туулах замыг s -ээр тэмдэглэв). Энэ утга өмнөх утгатай алдааны хүрээнд бараг тохирч байна.

Хэрэв бичих хурд хангалтай өндөр юмуу эсвэл бөөмцөрийн хурд бага бол бөөмцөр хөдөлгөөний эгшин бүрт толбо байдлаар бүртгэгддэг (Зураг 4). Энэ тохиолдолд бөөмцөрийн хөдөлгөөний хугацааг хэмжиж энэ хугацаанд туулсан замын хэмжээг окулярын хуваарийн үнийг ашиглан шууд тодорхойлоод мөн л дээрх томъёог ашиглан эдгээрийн харьцаагаар хурдыг тодорхойлж болно. Зураг 4-т өгөгдсөн бөөмцөрийн координат ба хугацаанаас түүний хөдөлгөөний дундаж хурдыг хэмжвэл $v = 49.5 \text{ мкм/с}$ байхыг тогтоож болно.

Энэ үр дүнгээс харахад ямарч түлшний шаталтын эхний шатанд утааны хурд бага байх

бөгөөд бүрэн шаталтын горимд шилжих үед утааны хурд эрс ихэсдэг нь харагдаж байна. Урсгал тасралтгүйн тэгшитгэлийг ашиглан энд хэмжсэн хурдаар галаас гарч байгаа утааны хурдыг хэмжиж болно. Энэ хэмжигдэхүүний

утга утааны цахилгаан шүүлтүүрийн тооцоонд чухал ач холбогдолтой байдаг. Ердийн задгай галаас гадагшилж байгаа утаа хурд ойролцоогоор 0.05-0.07 м/с байдаг.

a) $t = 31.57$ cb) $t = 32.50$ cc) $t = 33.10$ cd) $t = 33.60$ c

Зураг 4. Шаталтын эхний үед ялгарах бага хурдтай бөөмцөрийн хөдөлгөөн (Байрлал бүрд харгалзах хугацааны эгшинийг доор нь тэмдэглэв. Өсгөлт 70х, окулярын хуваарийн үнэ 10 мкм).


Харин агаарын чанарын албаны лабораторит шалгасан хэмжилтийн үр дүнгээр зуухнаас гарах утга үнэхээр 1-3 м/с байдаг. Харьцангуй бага хурдтай хөдөлж байгаа бөөмцөрийн хөдөлгөөнийг ажиглахад тэдгээр нь чиглэсэн хөдөлгөөнөөс гадна эмх замбараагүй хөдөлж байдаг. Эмх замбараагүй хөдөлгөөний дундаж хурд тэгтэй тэнцүү байх нь ойлгомжтой. Утааг битүү саванд оруулж ажиглалт хийх үед энэ хөдөлгөөн тод ажиглагдана.

Бид утааны хөдөлгөөний хурдыг өөрсдийн боловсруулсан утаанд мониторинг хийх аргадаа тулгуурлан тогтоож агаарын чанарын албаны лабораторит батлах хэмжилт хийснээс гадна Питот хоолойгоор тодорхойлсонутгатай жишив. Эдгээр хэмжилтийн утгатай харьцуулбал манай боловсруулсан утааны хурдыг хэмжих энэ процедур нэлээд үнэмшилтэй байгаа нь тогтоогдлоо.

Эцэст нь утааны хурдыг хэмжих тохиолдолд микроскопын өсгөлт өндөр байх төдийлэн шаардлагагүй, харин бөөмцөрүүдийн дүрс маш бага хэмжээтэй байх өсгөлтийг сонгон авах хэрэгтэй гэдгийг тэмдэглэе. Энэ хэмжилтэд 10х өсгөлттэй объектив, 7х-10х өсгөлттэй хуваарьтай окуляр ашиглах хамгийн тохиромжтой.


Бөөмцөрийн хэмжээ, хэмжээгээр түгэх түгэлт
Утааны бөөмцөрийн хэмжээг мөн л дээрх процедурыг ашиглан хэмжинэ. Утааг камерт оруулж тогтвортой жигд урсгал бий болгосны дараа орох ба гарах хоолойг зэрэг хаана. Энэ үед камер утаагаар дүүрч утаа камер дотор бараг жигд тархсан байна. Микроскопын харааны талбайд үүсэж байгаа бөөмцөрийн дүрсийн хөдөлгөөн эмх замбараагүй байдаг тул тэдгээрийн хэмжээг нүдээр ажиглан тогтооход бэрхшээлтэй байдаг. Ийм учраас микроскопыг фокуслан утааны бөөмцөрийн тод дүрсийг гарган авч түүний хөдөлгөөний бичлэгийг

хийнэ. Битүү камер дотор байгаа утааны бөөмцрүүд эмх замбараагүй хөдөлгөөн хийх бөгөөд тод дүрс өгч байгаа бөөмцөрийн хэмжээг окулярын хуваариар тогтооно.



Зураг 5. Микроскопын окулярын хавтгайд үүсэж буй бөөмцөрийн дүрс (Өсгөлт 400х, окулярын хуваарийн үнэ $d=2.25$ мкм).

Тухайлбал, Зураг 5-д хэд хэдэн бөөмцөрийн тод дүрсийг үзүүлэв. Энэ зургийн хуваарь дээр байрлаж байгаа хоёр бөөмцөрийн хэмжээ харгалзан 4.5 мкм, 6.7 мкм байна. Ийм байдлаар тамхины утааны доторхи 300 гаруй бөөмцөрийн шугаман хэмжээг олж бөөмцөрийн хэмжээгээрээ түгэх түгэлтийг гаргав (Зураг 6). Энэ хэмжилтийн үр дүнгээс үзэхэд тамхины утааны бөөмцөрийн минимум хэмжээ 0.6 мкм, максимум хэмжээ 26 мкм бөгөөд ийм хэмжээтэй бөөмцөрүүд 1000-аас цөөнгүй бөөмцөр дотор нэг удаа тааралдах боломжтой байдаг. Энэ түгэлтийн хувьд бөөмцөрийн дундаж хэмжээ 6.05 мкм, хамгийн магадлангүй хэмжээ нь 4.4 мкм байх нь харагдаж байна. Тамхины утааны бөөмцөрийн хэмжээ ийм бага байдаг учраас Ми сарнилын улмаас утаа хөх цэнхэр харагддаг гэсэн дүгнэлтийг хийж болно. Гэрлийн сарнилын онолын үүднээс авч үзвэл утаа бараг хөх ягаан өнгөтэй харагдах ёстой боловч хүний нүдний мэдрэх чадвар энэ мужид цэнхэр өнгө дээр хамгийн их байдаг тул утааны өнгө ингэж тодорхойлогддог болж таарч байна.



Зураг 6. Утааны бөөмцөрийн хэмжээгээр түгэх түгэлт.

Энэ аргаар бөөмцөр хатуу эсвэл шингэн төлөвт байгаа эсэхээс нь үл хамааран түүний хэмжээг тодорхойлж болно. Туршилтын явцад хийсэн ажиглалтаас харахад бөмбөрцөгт ойр хэлбэртэй бөөмцөр ихэвчлэн шингэн хэлбэрт байгаа нь харагддаг. Үүнийг цаашид бөөмцөрийн хэлбэрт хийх морфологийн судалгаагаар нарийвчлан тогтоож болох юм.

Бөөмцөр хоорондын зай

Утааны доторхи бөөмцөрүүд өөр өөр хэмжээтэйгээс гадна тэдгээрийн хоорондох зай харилцан адилгүй байдаг. Бөөмцөр хоорондын зай нь утааны механик шинж чанарыг тухайлбал утааны өтгөн, сийрэг чанарыг үзүүлэх нэг чухал хэмжигдэхүүн юм. Утааны өтгөн, сийрэг чанарыг түүн дотор байгаа бөөмцөрийн концентраци буюу тоон нягт гэсэн хэмжигдэхүүнээр тодорхойлдог боловч бөөмцөр хоорондын зайгаар ч бас илэрхийлэх боломжтой. Утааны доторхи бөөмцөрүүдийн хоорондын зай их байх тусам утаа сийрэг, харин бага байхад утаа өтгөн байдаг. Ийм учраас энэ хэмжигдэхүүн утааны оптик шинж чанартай ч бас холбоотой болдог.

Бөөмцөр хоорондын зайг хэмжихийн тулд утааг камерт оруулж өмнөхийн адил жигд урсгал үүсгэнэ. Ийм жигд урсгалтай үед бөөмцөр хоорондын зайг окуляр хуваарийг ашиглан хэмжиж авна. Зураг 5-д байгаа хуваар дээр байрлах гурван бөөмцөрийн хувьд хоорондох зай нь харгалзан 96,75 мкм, 27 мкм байна. Утааны бөөмцөр хоорондын зайг нарийвчлан ажиглахад утааны урсгалын дагуу ба хөндлөн чиглэлд бөөмцөр хоорондын зай бага зэрэг ялгаатай байгаа нь ажиглагддаг. Үүнээс гадна хөндлөн чиглэлд хэмжсэн бөөмцөр хоорондын зай хугацаанаас хамаарч хүндийн хүчний дагуу

ба хөндлөн чиглэлд мөн ялгаатай болох хандлага ажиглагддаг.

Бөөмцөрийн концентраци

Эхлээд утааг камерт оруулж утааны стационар урсгал бий болгосны дараа утааны бөөмцөр хоорондын зай болон бөөмцөрийн хэмжээг тогтооно. Бөөмцөр хоорондын дундаж зайг тодорхойлохдоо нэг шугам дээр оршиж байгаа хоёр бөөмцөрийн хоорондын зайг окулярын хуваарийг ашиглан хэмжинэ. Энэ хэмжилтийг олон тооны хос бөөмцөрийн хувьд гүйцэтгэж бөөмцөр хоорондын дундаж зайг тогтооно. Бөөмцөр хоорондын зайг l_{avr} гэж үзвэл утааны доторхи бөөмцөрийн концентраци буюу тоон нягтыг дараах илэрхийллээр тодорхойлж болно:

$$n \approx \frac{1}{l_{avr}^3}.$$

Энэ утга нь утааны урсгал дахь бөөмцөрийн концентраци юм. Энэ илэрхийллийг ашиглан тооцоо хийж төрөл бүрийн түлшний шаталтаас гарах утааны бөөмцөрийн концентрацийг тодорхойлж болно.

Агаарын бохирдлыг судалгаанд тоосонцорын концентрацийг $г/м^3$ нэгжээр илэрхийлдэг. Энэ нь утааны нэгж эзлэхүүнд байгаа бөөмцөрийн масс юм. Манай судалгааны аргаар энэ хэмжигдэхүүнийг ч мөн тодорхойлох боломжтой. Бөөмцөрийн материалын нягт α бол түүний масс $\mu \approx \alpha d_{avr}^3$ байх учраас утааны тоосонцорын нягт дараах томъёогоор илэрхийлэгдэнэ:

$$\rho = \mu n \approx \alpha \frac{d_{avr}^3}{l_{avr}^3}.$$

Тамхины утааны хувьд бөөмцөрийн дундаж хэмжээ нь 6 мкм, бөөмцөр хоорондын зай 56 мкм байдаг. Тамхины утааны бөөмцөрийн материалын нягт $\sim 1200 \text{ кг}/м^3$ байдаг [8]. Иймээс тамхины утааны доторхи бөөмцөрийн массаар илэрхийлэгдсэн концентраци буюу утааны доторхи бөөмцөрийн нягт дараах утгатай байна:

$$\rho = (1.5 \div 1.6) \cdot 10^{-3} \frac{г}{см^3}.$$

Агаарын бохирдлын судалгаанд нэгж үүсгэгчийн ялгаруулах тоосонцорын эмиссийн хэмжээг илэрхийлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Өнөөдөр Монгол улсын хэмжээнд тухайн үүсгэгчийн ялгаруулах нийт тоосонцорын массаар нь уг үүсгэгчийн бохирдуулах чанар буюу эмиссийг үнэлж тогтоодог. Энэ нь агаарын бохирдлын үнэлгээнд чухал боловч судалгааны ажилд параметр болгон хэрэглэхэд тохиромж муутай байдаг. Харин нэгж үүсгэгчийн бохирдуулагч

ялгаруулах чадварыг хувьд нэгж хугацаанд агаар мандал руу оруулж байгаа тоосонцорын хэмжээгээр нь үнэлбэл илүү тохиромжтой. Үүнийг судалгааны параметр болгон авахад ч тохиромжтой юм. Дээр тодорхойлсон утааны доторхи бөөмцөрийн нягтыг ашиглан энэ параметрийг зохиоё. Утааны нэгж эзлэхүүнд ρ масстай бөөмцөр агуулагдах бөгөөд энэ нь v хурдтайгаар гадагшилна. Нэгж хугацаанд урсан гарах утааны эзлэхүүн Sv (S -утаа гадагшлах хоолойн хөндлөн огтлолын талбай) учраас энэ утааг гаргаж байгаа үүсгэгчээс нэгж хугацаанд агаар мандал руу орох бөөмцөрийн хэмжээ дараах томъёогоор илэрхийлэгдэнэ:

$$m = \rho Sv.$$

Энэ хэмжигдэхүүн нь үүсгэгчийн бохирдол ялгаруулалтыг үзүүлэх бөгөөд г/с нэгжтэй байна. Үүнийг үндэслэн ширхэг тамхинаас агаар луу орох бохирдлын хурд $m \sim 1.5 \frac{\text{мг}}{\text{с}}$ байна гэдгийг тооцоолон гаргаж болно.

Дүгнэлт

Бидний дэвшүүлж буй энэ аргаар утааны доторхи бөөмцөрийн төдийгүй дисперслэгдсэн бусад орчны (цементийн үйлдвэрлэл, шүршдэг будагтай орчин, уур манантай орчин зэрэг) дотор байгаа бөөмцөрийн механик шинж чанарыг лабораторийн нөхцөлд бүрэн тодорхойлж болно. Энэ аргыг цахилгаан оронд хэрэглэх замаар бөөмцөрийн цахилгаан шинж чанарыг ч бас тодорхойлох боломжтой юм. Энэ арга нь түргэн, найдвартай төдийгүй илүү хямд төсөр юм. Энэ аргыг ашиглан тогтоосон утааны механик шинж чанарыг тодорхойлох хэмжигдэхүүнүүдийн утга бусад арга, багаж ашиглан хэмжсэн үр дүнтэй алдааны хязгаар дотор давхацдаг.

Сарнисан гэрлийн эрчим сарниулагч төвүүдийн тоонд пропорциональ байдаг. Ийм учраас судалж байгаа системийн сарниулагч төвийн

концентраци бага байвал бүртгэгдэж байгаа гэрлийн эрчим бага байх бөгөөд энэ нь энэ аргыг хэрэглэх хязгаарыг тогтоож байдаг.

Энэ аргачлалаар утааны бөөмцөрийн хэмжээг тогтоох нь хэд хэдэн давуу талтай. Үүний нэг нь бөөмцөрийн механик шинж чанарыг бодит хугацаанд нь хэмжиж чаддаг. Нөгөө талаас хөвөгч бөөмцөрийн хэмжээг тогтоож чаддагаараа онцлогтой.

Ашигласан материал

- [1] M.A.Liberman, "Introduction to Physics and Chemistry of Combustion", Springer-Verlag, (2008).
- [2] J.Warnatz, et. al., "Combustion: Physical and Chemical Fundamentals, Modeling and Simulation, Experiments, Pollutant Formation", Springer, 4th ed., (2006).
- [3] K.S.Sajwan, et. al., "Coal Combustion Byproducts and Environmental Issues", Springer Science+Business Media, Inc., (2006).
- [4] P.Lu et al, Journal of Hazardous Materials, 199–200, 272–281, (2012)
- [5] P. G. Satsangi, Int. J. Environ. Sci. Technol. 11, 217–232 (2014)
- [6] Sadezky et al., Carbon, 43, 1731–1742, (2005)
- [7] J.Vanchinkhuu et al, Вестник Бурятского Государственного Университета: Химия. Физика, Вып. 2-3, 18-25, (2016).
- [8] T.J.Johnson, et al, Journal of Aerosol Science 75, 9–16 (2014).
- [9] M.W.McElroy et. al, Science vol 215, iss. 4528, 13-18, (1982)
- [10] C. Ehrlich et al., Atmospheric Environment, 41, 6236–62548 (2007)
- [11] P.Chylek, et al, Applied optics, 20, No. 17, 1, (1981)
- [12] M. Schnaiter et al., Journal of Aerosol Science, 34, pp. 1421–1444, (2003)

Нарны цацраг дэлхийн агаар мандлыг нэвтрэн газрын гадаргууд ирэхдээ шингэх ба сарних замаар эрчим нь сулардаг. $I_{\lambda 0}$ эрчимтэй нарны цацраг агаар мандлын дээд хил дээр буюу A_1 цэг дээр тусч байна гэе. Тодорхой долгионы урттай нарны цацраг B^1 цэгээс B цэгт ирэхэд эрчим нь:

$$dI_{\lambda} = -\alpha_{\lambda} \cdot \rho \cdot I_{\lambda} \cdot dS \quad (1)$$

хэмжээгээр буурна. Энд: $dS=BB^1$, ρ -агаарын нягт, α_{λ} - λ долгионы урттай цацраг нэгж масстай хэсгийг нэвтрэхэд харгалзах сулралын коэффициент. Газрын гадаргуу дээрх A цэг дээр ирж байгаа нарны цацрагийн урсгал нь:

$$\int_{I_0}^{I_{\lambda}} \frac{dI_{\lambda}}{I_{\lambda}} = - \int_0^S \alpha_{\lambda} \cdot \rho \cdot dS \quad (2)$$

тэгшитгэлээр тодорхойлогдоно.

Гурвалжин A_2AA_1 -ээс $\frac{AA_1}{AA_2} = \frac{1}{\sinh \theta}$, нөгөө

$$\text{талаас } \frac{AA_1}{AA_2} = \frac{M}{M_0} = m \quad (3)$$

болохыг харж болно. Иймд $m = \frac{1}{\sinh \theta}$ (4)

болно.

Үүнд: m -агаар мандлын оптик масс, h_0 -нарны хөөрөх өндөр. (4) томъёо нарны өндөр 20^0 -аас дээш байхад агаар мандлын массыг нилээд нарийвчлалтай илэрхийлдэг боловч нарны өндөр бага болоход алдаа нь тооцохоор хэмжээнд хүрдэг тул илүү нарийвчлалтай өөр томъёог хэрэглэдэг. (2) ба (3) томъёоноос:

$$\ln \frac{I_{\lambda}}{I_{\lambda 0}} = -\alpha_{\lambda} \cdot M_0 \cdot m \quad (5)$$

ба $M_0 \cdot \alpha_{\lambda} = \tau_{\lambda}$ гэж тэмдэглэвэл томъёо (5)-с λ долгионы урттай нарны монохромат цацрагийн эрчмийг

$$I_{\lambda} = I_{\lambda 0} \cdot e^{-\tau_{\lambda} \cdot m(\theta)} \quad (6)$$

олж болно. Үүнийг Буге-Ламбертийн хууль буюу агаар мандалд нарны шулуун цацрагийн эрчим сулрах хууль гэнэ. τ_{λ} -ийг спектрийн тухайн муж дахь агаар мандлын ерөнхий оптик зузаан гэж нэрлэдэг.

Агаар мандал дахь нарны цацрагийн эрчмийн сулралын хууль буюу Буге-Ламбертийн хуулиас агаар мандлын оптик зузааныг илэрхийлж бичвэл:

$$\tau_{\lambda} = -\frac{1}{m(\theta)} \ln \left(\frac{I_{\lambda}}{I_{\lambda 0}} \right) = \frac{1}{m(\theta)} \ln \left(\frac{I_{\lambda 0}}{I_{\lambda}} \right) \quad (7)$$

болно. Энд: $I_{\lambda 0}$ - спектрийн тухайн мужид агаар мандлын гаднах хилд ирж буй нарны шулуун цацрагийн утга, I_{λ} - спектрийн тухайн муж дахь нарны шулуун цацрагийн хэмжсэн утга.

Агаар мандлын ерөнхий оптик зузааныг дараах хэлбэрээр буюу оптик зузаануудын нийлбэр байдлаар илэрхийлж болно [1].

$$\tau_{\lambda} = \tau_a(\lambda) + \tau_R(\lambda) + \tau_{O_3}(\lambda) + \tau_{mg}(\lambda) + \tau_{PW}(\lambda) \quad (8)$$

Үүнд: $\tau_a(\lambda)$ -аэрозолын, $\tau_R(\lambda)$ -Релейн сарнилын, $\tau_{O_3}(\lambda)$ -озоны, $\tau_{mg}(\lambda)$ -холимог хийн, $\tau_{PW}(\lambda)$ -усны уурын оптик зузаан тус тус болно. (7) болон (8) томъёоноос аэрозолын оптик зузааныг тодорхойлбол дараах хэлбэртэй олдоно [1,2].

$$\tau_a(\lambda) = \frac{1}{m(\theta)} \left(\ln I_{\lambda 0} - \ln I_{\lambda} \right) - (\tau_R(\lambda) + \tau_{O_3}(\lambda) + \tau_{mg}(\lambda) + \tau_{PW}(\lambda)) \quad (9)$$

Аэрозолын оптик зузаан нь орон зай болон цаг хугацааны хувьд өөрчлөгдөж байдаг хэмжигдэхүүн бөгөөд түүнийг тодорхойлох зорилгоор скайрадиометр, нарны фотометр, эсвэл шилэн шүүлтүүрүүд бүхий актинометрийн тусламжтайгаар газрын гадаргад ирж буй нарны шулуун цацрагийг хэмждэг.

В. Ангстромын экспонент

Ангстромын экспонент нь аэрозолын оптик зузааны гэрлийн долгионы уртаас хамаарах хамаарлыг илтгэдэг параметр юм. Энэхүү параметр нь тухайн ажиглалт, судалгаа хийж буй бүс нутгийн агаар мандалд агуулагдаж буй аэрозолын шугаман хэмжээстэй хамааралтай бөгөөд ангстромын экспонентийн их утга нь тухайн агаар мандал дахь аэрозолын хэмжээс харьцангуй жижиг байгааг, харин бага утга нь тухайн агаар мандалд харьцангуй том хэмжээст аэрозол голчлон түгж буйг тус тус илтгэдэг. Жишээлбэл: $\alpha \ll 1$ үед агаар мандалд том ширхэгтэй буюу эффектив радиус нь $0.5 \mu\text{m}$ -аас их байх аэрозол давамгайлна хэмээн үнэлж болно. Харин, $\alpha \geq 1$ үед агаар мандалд жижиг ширхэгтэй буюу $0.5 \mu\text{m}$ -аас бага эффектив радиустай буюу биомасс шатааснаас үүссэн юмуу хотын агаарын бохирдолтой холбоотой аэрозол давамгайлж байна хэмээн үзэж болно. Ангстромын экспонентийг спектрийн тухайн муж дахь аэрозолын оптик зузаан болон долгионы уртын харьцаагаар тодорхойлдог [1].

$$\frac{\tau_\lambda}{\tau_{\lambda_0}} = \left(\frac{\lambda}{\lambda_0}\right)^{-\alpha} \quad (10)$$

α -ангстромын экспонентийг тодорхойлбол:

$$\alpha = -\frac{\ln \frac{\tau_\lambda}{\tau_{\lambda_0}}}{\ln \frac{\lambda}{\lambda_0}} \quad (11)$$

болно.

С. Нэг сарнилын альбе́до

Нэг сарнилын альбе́до (НСА) буюу single scattering albedo гэх энэхүү параметр нь агаар мандалд агуулагдаж буй аэрозолын бөөмс дээр гэрэл сулрах үзэгдлийг илэрхийлэх сулралын оптик параметруудийн шинж чанарын тодорхойлолтонд чухал ач холбогдолтой юм. Нэг сарнилын альбе́до нь гэрлийн нийт сулрал дахь сарнил болон шингээлтийн коэффициентуудын хоорондын харьцаагаар тодорхойлогддог [1]:

$$\omega = \frac{\sigma_s}{\sigma_a + \sigma_s} \quad (12)$$

Үүнд: ω -нэг сарнилын албе́до, σ_s -сарнилын коэффициент, σ_a -шингээлтийн коэффициент. Орчны харьцангуй чийгшил дэхь сарнилын коэффициентийг Кастин-Ханил нарын тэгшитгэлээр тооцоолбол:

$$\sigma_s(R) = \sigma_0(1 - R)^{-\gamma} \quad (13)$$

Дээрх тэгшитгэлд R -харьцангуй чийгшил, γ -аэрозолын бөөмсийн конденсацын идэвхийн параметр, σ_0 -аэрозолын хуурай бөөмсийн сарнилын коэффициент. Аэрозолын шингээлтийн коэффициентийг дараах байдлаар тодорхойлно:

$$\sigma_a = \sigma_m \times 10^{-3} \times M \quad (14)$$

Үүнд: σ_a -шингээлтийн коэффициент, σ_m -тодорхойлсон шингээлтийн хөндлөн огтлол, M -массын концентрац. (13) болон (14) тэгшитгэлүүдийг (12) томъёонд орлуулан бичвэл нэг сарнилын альбе́до ω нь дараах байдалтай олдоно [3,4].

$$\omega = (1 + \frac{M}{10^3 \sigma_0} \sigma_m (1 - R)^\gamma)^{-1} \quad (15)$$

Нэг сарнилын альбе́догийн утга $\omega \leq 1$ байх бөгөөд хэрвээ цацрагийн эрчим зөвхөн сарнилын нөлөөгөөр суларч байвал нэг сарнилын альбе́догийн тоон утга 1 байна. Харин тоон утга нь 1-ээс бага байвал агаар мандал дундуур нэвтрэн газрын гадаргад хүрч буй нарны цацрагийн эрчим зөвхөн сарнилаар биш мөн шингээлтийн нөлөөгөөр суларч буйг илэрхийлнэ.

Аэрозо́лын эзэлхүүний тархалт:

$(dV/d(\ln r))$ нь нэгж агаар мандал дахь тухайн $r + dr$ радиустай аэрозо́лын бөөмсийн нийт эзэлхүүнийг илэрхийлнэ.

III. СУДАЛГААНЫ ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Японы Чибегийн Их Сургуулийн эрдэмтэдтэй хамтарсан суурь судалгааны багаж Скайрадиометр /РОМ-1/-ийн хэмжилтийн өгөгдлөөр Улаанбаатар хот /47.55N, 106.53E, д.т.д 1310м/ орчимд өвөл, зун болон ойн түймрийн утаатай байх үед агаарын бохирдлын үзүүлэлтүүд болох 500нм-ийн долгионы уртад харгалзах аэрозо́лын оптик зузаан, нэг сарнилын альбе́до болон ангстромын экспонентийн статистик үзүүлэлтүүдийг харгалзан Хүснэгт 1, 2, 3-т үзүүлээ.

Хүснэгт 1. Өвөл, зун болон ойн түймрийн утаатай байх үед 500нм-ийн долгионы уртад харгалзах аэрозо́лын оптик зузааны статистик үзүүлэлтүүд

Улирал	Хэмжилтийн тоо	Дундаж	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Стандарт хазайлт
Өвөл	221	0.27	0.07	0.97	0.18
Зун	235	0.39	0.03	1.95	0.32
Түймрийн утаатай	34	1.07	0.69	1.65	0.15

Хүснэгт 1-ээс харвал аэрозо́лын оптик зузааны зун, өвлийн дундаж утгын ялгаа нь 0.12 буюу дундаж утгын хувьд өөрчлөлт багатай байна. Харин 2016 оны 7-р сарын 20-24 буюу ойн түймрийн утаатай байх үеийн дундаж утга нь харьцангуй огцом өссөн байна. Хамгийн их утга нь зун 1.95, хамгийн бага утга нь өвөл 0.03 байгаа нь ажиглагдаж байна.

Хүснэгт 2. Өвөл, зун болон ойн түймрийн утаатай байх үеийн ангстромын экспонентийн статистик үзүүлэлтүүд

Улирал	Хэмжилтийн тоо	Дундаж	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Стандарт хазайлт
Өвөл	221	1.53	0.13	2.30	0.29
Зун	235	1.07	0.01	1.76	0.37
Түймрийн утаатай	34	1.31	0.92	1.65	0.15

Ангстромын экспонентын дундаж утга нь өвөл, зун болоод түймрийн утаатай байх аль ч нөхцөлд $\alpha \geq 1$ байгаа нь 0.5 μm -ээс бага буюу биомасс шатаалтын процесстэй холбоотой аэрозоль давамгайлж байгааг харуулж байна. Хамгийн


бага утга нь зун 0.01, хамгийн их утга нь 2.30 буюу өвлийн улиралд ажиглагдаж байна.

Нэг сарнилын альбедон дундаж утга өвөл 0.94, зун 0.89 буюу өвлийн дундаж их байгаа нь өвлийн улиралд сарнилын нөлөөтэй гэрлийн эрчмийн сулрал давамгайлж байгааг илтгэж байна.


Хүснэгт 3. Өвөл, зун болон ойн түймрийн утаатай байх үед 500нм-ийн долгионы уртад харгалзах нэг сарнилын альбедон статистик үзүүлэлтүүд

Улирал	Хэмжилтийн тоо	Дундаж	Хамгийн бага утга	Хамгийн их утга	Стандарт хазайлт
Өвөл	221	0.94	0.81	1.00	0.05
Зун	235	0.89	0.73	1.00	0.08
Түймрийн утаатай	34	0.96	0.91	1.00	0.02

